



НАЗАРЫН

ҮНДСЭН БАРИМТЛАЛ

Бидний тухай – Бидний Итгэл

НАЗАРЫН ЧУУЛГАНЫ
ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛ
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ.

© Зохиогчийн эрх 2015. Бүх эрх Назарын Чуулганд хадгалагдана.

Библийн эшлэлүүдийг Ариун бичээс Нийгэмлэгийн
2004 оны Ариун Библиэс авсан болно.

ГАРЧИГ

НАЗАРЫН ҮНДСЭН БАРИМТЛАЛ

УЭСЛИЙН-АРИУН БАЙДЛЫН ӨВ

БИД ДАЯАР ЧУУЛГАНЫХАН

ҮНЭТ ЗҮЙЛС

ЭРХЭМ ЗОРИЛГО

НАЗАРЫН ОНЦЛОГ

УЭСЛИЙН ТЕОЛОГИ

ИТГЭЛИЙН ТУНХАГ

ЧУУЛГАНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

ЧУУЛГАНЫ БҮТЭЦ


ЧУУЛГАН: ҮНДЭСНИЙ, БҮСИЙН БА ЕРӨНХИЙ

НЭГДМЭЛ ЧУУЛГАН

ГАЗАРТ БА ТЭНГЭРТ ӨӨРИЙН
ТЭНГЭРЛЭГ ДЭЭД
ХЭЛБЭРЭЭР ОРШИН БУЙ
БУРХАНЫ ЧУУЛГАН НЬ
ХАМТДАА ЦУГЛАН,
НЭГДМЭЛЭЭР
МАГТАН ХҮНДЭЛЖ,
ЗААЖ СУРГАХЫН
ЗЭРЭГЦЭЭ БУРХАНЫ ХҮҮТЭЙ
АДИЛ БАЙХАД НЬ **ХҮН**
БҮРТ ТУСАЛДАГ.

ФАЙНИС Ф. БРЭСИ

НАЗАРЫН ЧУУЛГАНЫ АНХНЫ ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



НАЗАРЫН ҮНДСЭН БАРИМТЛАЛ



Шинэ үеийн сүнслэг удирдагчид ба өсөн нэмэгдэж буй итгэлийн ахан дүүстээ зориулан гаргаж буй чуулганы сургаалын үндсэн ойлголтууд, түүх, теологи, үйлчлэл, санхүүжилт ба эдгээрийн хоорондын харилцан хамаарлын талаарх ном, хэвлэлүүд маань аль болох товч, энгийн хэлбэрээр бичигдсэн, ойлгоход хялбар хэллэгтэй байх шаардлагатай.

Назарын Чуулган яагаад Уэсли-Армины уламжлалын дагуу дэлхийн хэмжээнд Ариун байдлын ба Агуу Захирамжийн хөдөлгөөн болон хөгжсөөр өнөөг хүртэл оршин байгаад Назарын Үндсэн Баримтлал хариу өгөх болно.

Назарын Үндсэн Баримтлал нь сүм яагаад сүнслэг ариун байдлыг түгээн дэлгэрүүлэхийн төлөө байдаг, яагаад Христийн дагалдагчдыг үндэсний хэмжээнд бэлтгэн үйлчлэх зорилготой байдаг талаар сүм, нийгмийн удирдагчдад илүү сайн ойлголт өгнө.

Назарын Үндсэн Баримтлалыг цахим хуудаснаас унших боломжтой. www.nazarene.org дахь Ерөнхий Удирдлагын Зөвлөлийн хуудас руу орох эсвэл

<https://nazarene.org/nazarene-essentials> дээр шууд дарж орж болно. Мөн энэхүү сайтаас Назарын Үндсэн Баримтлал-аас гадна өөр эх сурвалжуудыг бусад хэл дээр авах боломжтой.

Та Назарын Үндсэн Баримтлалыг уншин танилцах явцдаа Назарын чуулганы талаар илүү ихийг мэдэхээс гадна Есүс Христийн Сайнмэдээг дуулгавартайгаар тараах чуулганы хүсэл тэмүүллийн талаар тодорхой ойлголттой болох болно.

Тэмдэглэл: Назарын Үндсэн Баримтлал бол нэмэлт баримт бөгөөд www.nazarene.org дахь Назарын Чуулганы Бодлого-ыг орлуулах баримт биш.



Жон Уэсли, 1703-1791
Методист Хөдөлгөөнийг Үүсгэн байгуулагч

УЭСЛИЙН АРИУН БАЙДЛЫН ҮНЭТ ӨВ

Христийн “нэгэн цул, ариун, нэгдмэл, элчийн” чуулган нь Шинэ ба Хуучин Гэрээнд тэмдэглэгдэн үлдсэн Бурханы хүмүүсийн түүхийг өмчлөөд зогсохгүй бүхий л цаг хугацааны түүчээнд Бурханы хүмүүсээр дүүргэгддэг Христийн бүх хэлбэрийн цуглаан билээ. Дэлхий даяарх Христитгэлийн эхний таван зууны итгэл үнэмшил нь Назарын чуулганы итгэл үнэмшлийг илэрхийлж байсныг харж болно.

Мөн Үгийг номлох, чуулганы үйл ажиллагааг гүйцэтгэх, элчийн итгэлийн үйлчлэлийг сахих, үйлчлэлдээ дадлагажих, Христийг даган дуурайсан амьдралаар амьдрах, Түүнтэй адилаар бусдын төлөө үйлчлэх зэргээс түүхэн чуулганыг тодорхой ойлгож болно. Чуулган бол Библийн дагуу ариун амьдралаар амьдрахаар дуудагдсан, бүхий л ариун байдлын сургаалын дагуу Бурханд өөрийгөө бүрэн дүүрэн зориулахаар эргэлт буцалтгүй шийдсэн ариун хүмүүсийн нэгдэл юм.

16-р зууны Английн Хувьсгал болон 18-р зууны Уэслийн шинэчлэлээр бидний Христитгэлийн үнэт өв бий болсон гэж үздэг. Жон болон Чарльз Уэсли нарын номлолоор дамжуулан Англи, Шотланд, Ирланд, Уэльс зэрэг улсууд өөрсдийн гэм нүглээсээ эргэж, Христийн үйлчлэлд хүчтэйгээр бэлтгэгдэж эхэлсэн билээ. Энэхүү шинэчлэлд сайтар боловсруулаагүй түүхий номлолууд, гэрчлэлүүд, сахилгажуулалтууд хийгдэж байснаас гадна “нийгмийнхэн”, “анги давхаргынхан” эсвэл “бүлэглэлийнхэн” хэмээгдсэн чин сэтгэлтэй дагалдагчдын хүрээний хүмүүс оролцсоноороо онцлог байжээ.

Уэслийн шинэчлэлд итгэлээрээ дамжуулан нигүүлслээр зөвтгөлд хүрдэгт итгэх, итгэлээрээ дамжуулан нигүүлслээр ариусгагддаг буюу Христийн дотор төгст тооцогддог, нигүүлсэл авсныг гэрчилж буй Сүнсний гэрчлэлд итгэх зэрэг теологийг баримталдаг.

Жон Уэслийн хамгийн гол хувь нэмэр бол итгэлийн амьдралд Бурханы нигүүлсэнгүй хангалтууд байдаг учраас ариун байдалдаа бүхий л талаар анхааралтай хандах хэрэгтэй гэдгийг гаргаж тавьсанд байгаа юм. Түүний дэвшүүлсэн энэхүү чухал санаа нь дэлхий даяар танигдаж чадав. “Газар нутгийг бүтэцлэн тухайн газруудад сүнслэг ариун байдлыг дэлгэрүүлэх” зорилгоор 1784 онд Хойд Америкт Методист Эпископал Чуулган үүсгэн байгуулагдсан.

Христитгэлийн ариун байдлын үзэл баримтлалыг 19-р зууны дундуур шинэчлэн тодорхойлж хөгжүүлсэн байдаг. Массачусетст мужийн Бостон хотын Тимот Мерритт гэгч *Христэч Төгс Төгөлдөрт Хөтлөхүй* номыг хянан тохиолдуулжээ. Нью-Йоркийн Фиби Палмер нь бусдыг Ариун байдалд уриалах үүднээс мягмар гараг бүр уулзалт зохион байгуулж байсан ба улмаар олонд танигдсан илтгэгч, зохиолч, хянан тохиолдуулагч болжээ. 1867 онд Методист номлогчид болох Ж.А.Вүүд, Жон Инскип болон бусад номлогчид Нью-Жерсигийн Винландад анхны хамгийн урт хугацааны ариун байдлын цуврал цуглааныг санаачлан зохион байгуулснаар ариун байдлын төлөөх Уэслийн үйлчлэлийн цар хүрээг дэлхий дахинаа шинэчлэн тэлж чадсан билээ.

Христэч ариун байдлыг Уэслийн Методист, Чөлөөт Методист, Авралын Арми, зарим Меннонитууд*, Ахан дүүс болон Найзууд Христитгэлт нийгэмлэг зэрэг чуулганууд баримталдаг. Сайнмэдээ тунхаглагчид ариун

байдлын хөдөлгөөнийг Герман, Их Британи, Скандинав, Энэтхэг болон Австрали хүртэл түгээжээ. Шинээр ариун чуулганууд байгуулагдаж байсны дотор Бурханы Чуулган (Индиана мужийн Андерсон) хүртэл багтаж байлаа. Энэ бүхний үр дүнд ариун чуулганууд, хотын үйлчлэлүүд, сайнмэдээ тунхаглагчдын холбоо зэрэг үйлчлэлүүд хөгжин цэцэглэж эхлэв. Ийнхүү Назарын чуулган нь эдгээр олон олон ариун чуулгануудыг нэгэн нэгдмэл ариун чуулган болгох чин хүслийн үндсэн дээр төрөн гарсан нь энэ.

АРИУН БАЙДАЛ ДОТОРХ ЭВ НЭГДЭЛ

1887 онд Фред Хиллери Ардын Сайн Мэдээний Чуулганыг (Провиданс мужийн Рход аралд) зохион байгуулсан. Улмаар 1888 онд Илгээлтийн чуулган (Массачусетс мужийн Линн хот) бас нэгджээ. Энэ хоёроос гадна 1890 онд Шинэ Английн найман өөр цуглаан нэгдэж, Сайнмэдээний Ариун Байдлын Төв Холбоог үүсгэн байгуулсан байна. 1892 онд Анна С.Ханскомыг томилсон нь анхны Назарын гарал угсааны дагуу томилогдсон эмэгтэй удирдагч байв.

1894-95 онуудад Уильям Ховард Хүүпл нь Ариун байдлын гурван цугларалтыг Нью-Йоркийн Брүүклинд зохион байгуулсан нь Америкийн Пентекост Чуулганы Холбооны үүслийг тавьжээ. Энэхүү холбооны болон бусад Назарын чуулганы үүсгэн байгуулагчдын хувьд “пентекост” гэдгийг “ариун байдал” гэсэн үгтэй ижил утгатай гэж үзэж байв. Хилари болон Хүүпл нарын бүлгийнхэн 1896 онд хамтдаа нэгдэн 1899 онд Энэтхэгт, 1901 онд Капе-Вердед үйлчлэлээ эхлүүлсэн байна. Илгээлтийн ажилтан Хирам Рейнолдс 1902 онд Канадад цуглаан байгуулсан. Ингээд 1907 он хүртэл тэдний бүлгийнхэн Нова Скотиагаас Ловаг хүртэл үйлчилсэн байна.

1894 онд Роберт Ли Харрис нь Христийн Шинэ Гэрээний чуулганыг (Теннессигийн Миланд) байгуулжээ. 1895 онд түүний бэлэвсэн эхнэр Мари Ли Кагл баруун Техас хүртэл түгээн дэлгэрүүлсэн. 1901 онд С.Б.Жерниган анхны Чөлөөт Ариун Чуулганыг (Техасын Ван Алстин) байгуулсан. Эдгээр чуулганууд нэгдэн, 1904 онд Техасын Райсинг Стар хотод Христийн Ариун чуулганыг үүсгэн байгуулжээ. 1908 он гэхэд Жеоржиагаас Нью-Мексик хүртэл хүрээгээ тэлж, улмаар орон гэргүй, ядуучуудад үйлчлэн, өнчин хүүхдүүд болон ганц бие ээжүүдэд тусалж дэмжихээс гадна Энэтхэг болон Японы ажилчдыг хооронд нь холбож байв. Файнис Ф.Бреси болон Иосеф

П.Уидни нар өөр 100 гаруй хүмүүсийн хамт Назарын Чуулганыг 1895 онд Лос-Анжелест байгуулсан.

Итгэлээрээ дамжуулан ариусгагдсан Христэд итгэгчид нь Христийг үлгэрлэн харуулж, ядууст сайнмэдээг тунхаглах ёстой гэж тэд үздэг байв. Тэдний цаг, мөнгө сүнснүүдийн авралын төлөө, ядуусын хэрэгцээний төлөө Христийн үйлчлэлд зориулагдах ёстой хэмээн гүнээ итгэдэг байв.

Назарын Чуулган нь Америкийн баруун эрэг хавийн ихэнх газрууд, мөн зүүн Иллинойсийн зарим цуглаануудыг ч хамарч чадсан байна. Түүнчлэн Энэтхэгийн Калькуттад орон нутгийн үйлчлэлийг дэмжиж байлаа.

1907 оны аравдугаар сард чуулганы эрх бүхий тэнцвэрт удирдлагын загварчлалыг гаргахаар Иллинойс мужийн Чикаго хотноо Америкийн Пентекост Чуулганы Холбоо болон Назарын чуулган нэгдэн чуулжээ. Тухайн удирдлагууд нь хэдийн байгуулагдсан чуулганы бие даасан үйл ажиллагаанд төвөг учруулалгүй харин шинээр үүсгэн байгуулагдаж буй чуулгануудад дэмжлэг үзүүлэх, халамжлах, чуулгануудыг байгуулах, тэднийг урамшуулан дэмжих чиглэлээр ажиллаж байв. Чуулга уулзалтад Христийн Ариун Чуулганы төлөөлөгчид оролцов. Анхдугаар Ерөнхий Чуулга уулзалтын шийдвэрээр хоёр байгууллагын нэрнээс аль алинаас оруулан Назарын Пентекост Чуулган хэмээн нэрлэхээр тогтжээ. Бреси болон Рейнолдс нар ерөнхий зөвлөлийн удирдлагаар сонгогдсон байна.

1908 оны есдүгээр сард Х.Ж.Трумбаурын удирдлаганд байсан Пенсилванийн Христийн Ариун Чуулган, Назарын Пентекост Чуулгантай нэгджээ. 10 сарын 13-нд Техасын Пайлот Поинт хотод болсон хоёрдугаар Ерөнхий Чуулга Уулзалтаар Христийн Ариун Чуулганы Ерөнхий Зөвлөлд дахин хоёр сүм нэгдсэн байна.

Теннесси болон түүнтэй ойролцоох мужуудаас ариун хүмүүсийг нэгтгэсэн Пентекост Илгээлтийн Үйлчлэл байгууллага Нэшвиллд 1898 онд Ж.О.Москларкенаар удирдуулан байгуулагджээ. Тэд, пасторууд болон багш нарыг Куба, Гуатемала, Мексик, Энэтхэг зэрэг улсууд руу илгээж байв. 1906 онд Шотландын Глазгов хотын Паркхээд Уламжлалт Сүмээс Жорж Шарпыг Христийн ариун байдлын талаар сургаал заалаа хэмээн буруутгаж хөөсөн байна. Паркхээд Уламжлалт Сүм байгуулагдсан, мөн бусад уламжлалын сүмүүд ч үүсч байсан төдийгүй 1909 онд Шотландын

Христийн Пентекост Чуулган байгуулагдсан байна. 1915 онд Пентекост Илгээлтийн Үйлчлэл ба Шотландын Пентекост Чуулганыхан Назарын Пентекостчуудтай нэгджээ.

Тавдугаар Ерөнхий Чуулга Уулзалтаар (1919) чуулганы албан ёсны урсгалын нэрээ Назарын Чуулган болгон өөрчлөв. Учир нь 19-р зууны сүүлчээр чуулганы үүсгэн байгуулагчид чуулганы нэрийг сонгох үед “Пентекост” гэдэг үг ариун байдлын сургаалтай дүйцэх утгыг илэрхийлж чадахааргүй байжээ. Ийнхүү шинэхэн үүссэн урсгалын хувьд хүмүүсийн бүрэн гүйцэт авралын төлөөх сайнмэдээг тунхаглах үндсэн зорилгодоо үнэнчээр үлдэж чадсан юм.



Ерөнхий Чуулга Уулзалт, Пайлот Поинт, Техас, АНУ, 1908 оны 10-р сарын 13



БИД ДАЯАР ЧУУЛГАНЫХАН

1915 он гэхэд нэгтгэгдсэн байсан эцэг чуулгануудаар Назарын Чуулганы үндсэн баримтлалын онцлог шинжүүд дүрээ олсон байна. Цаашлаад цар хүрээгээ тэлэн олон улсын чанартай болжээ. Назарын урсгал нь АНУ, Энэтхэг, Капе-Верде, Куба, Канад, Мексик, Гуатемала, Япон, Аргентин, Их Британи, Швейцарь, Хятад болон Перу зэрэг улсуудад үүсгэн байгуулагдсан сүм чуулгануудыг дэмжих болов. 1930 он гэхэд Өмнөд Африк, Сири, Палестин, Мозамбик, Барбадос болон Тринидад зэрэг улсууд руу хүрээгээ тэллээ. Мексикийн В. Ж. Сантин, Японы Хироши Китагава, Энэтхэгийн Самуел Бхужбал зэрэг нутгийн удирдагчид энэ үйл явцад чухал үүрэг гүйцэтгэж байлаа. Ийнхүү Назарын урсгалд шинээр сүм чуулганууд нэгдэж байсан нь энэ урсгалын олон улсын шинж чанарыг улам бүр бэхжүүлсээр байв.

1922 онд Ж.Жи.Моррисон, Миннесотагийн Дакотас мөн Монтанад Лэймэний Ариун Нийгэмлэгийн ажилчид болон 1000 гаруй гишүүдийг сүмд нэгтгэж байжээ. Чунг Нам Сү (Роберт Чунг) Солонгос пасторуудын сүлжээ болон цуглааныг 1930 онд Назарын Чуулганд нэгтгэж байсан байна. Мөн

А.А.И.Бергийн удирдаж байсан Австрали дахь чуулганууд 1945 онд уг урсгалд нэгдэн оров. Алфредо Дел Россо Италийн чуулгануудыг 1948 онд Назарын урсгалд нэгтгэжээ. 1950-иад оны үед Өмнөд Африкийн Гефцибахын Итгэлийн Илгээлтийн Эздийн Холбоо болон Ловагийн Таборт байрладаг төв нь ч Назарынхантай нэгдэцгээжээ.

Олон Улсын Ариун Илгээлтийн байгууллагыг Давид Томас 1907 онд Лондон хотод үүсгэн байгуулж, Давид Жонес Африкийн өмнөд хэсэг хүртэл өргөжүүлэн ажиллажээ. 1952 онд Маклаганы удирдаж байсан Английн чуулганууд болон Африкийн үйлчлэл Назарт нэгдэв. 1934 онд Майнард Жэймс болон Жак Форд нар Их Британи улсад Калвари Ариун Чуулганыг үүсгэн байгуулаад 1955 онд Назарт нэгджээ.

Франк Гоффын 1918 онд Канадын Онтариод байгуулсан Сайнмэдээний Ажилчдын Сүм 1958 онд Назарын Чуулганд нэгдсэн. 1940-өөд онд Нигерчүүд Иеремиа У.Екайдемаар удирдуулан Назарын Нутгийн Чуулганыг байгуулсан бөгөөд тэд 1988 онд олон улсын биеийнхээ нэгэн хэсэг болон нэгдэцгээв. Эдгээр олон нэгдэлт нь Назарын чуулганы олон улсын шинж чанарыг илүү хүчирхэгжүүлсэн билээ.

Эдгээр хөгжил дэвшлийн үр дүнд Назарчууд Протестант хэв загвараас ялгаатай сүмийн загварыг зориудаар бий болгосон юм. 1976 онд Назарын урсгалын ирээдүйн дүр төрхийг тогтоохоор сургалтын комисс байгуулагдсан байна. 1980 оны тайланд бичсэнээр, олон улсын чанартай бодлогыг хоёр зарчим дээр тулгуурлан албан ёсоор батлан хэрэгжүүлэхийг Ерөнхий Чуулга уулзалтаас санал болгосон байдаг.

Нэгдүгээрт, Назарын чуулганууд болон бүсийн чуулганууд “өөрсдийн соёлын хувьд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн дэлхий даяарх итгэгчдийн нөхөрлөл” мөн болох нь танигдсан байх,

Хоёрдугаарт, “Назарын Чуулганы өвөрмөц ялгаатай үйлчлэл”-ийн нийтлэг зориулалт буюу тухайлбал “сүнслэг ариун байдлыг Назарын үндсэн зарчмыг тодорхойлдог, зөвшилцөж үл болох үндсэн зарчим дотор нэн чухал үндсэн суурь ойлголт болгон суулгаж, түгээн дэлгэрүүлэх нь тогтоогдсон байх,

1980 оны Ерөнхий Чуулга уулзалтаас “олон улсын теологийн зохицуулалт”-ыг Итгэлийн Тунхагт оруулан, бүхий л үйлчлэлийн хүрээнд теологийн сургалтын ач холбогдлыг чухалчлан, теологийн боловсрол олгох сургуулиудыг дэлхийн өнцөг булан бүрт бүрэн дүүрэн дэмжихийг уриалсан байна.

Чуулга уулзалтаас Назарчуудыг олон үндэстнээс бүрдсэн ариун хүмүүсийнхээ

хувьд илүү ихээр төлөвшихийг, “хүчтэй ба сул дорой, донор ба ашиг хүртэгч”-ээр нь дүгнэдэг колоничлолын сэтгэлгээнээс ангижирч, “энэ ертөнцийг цоо шинээр төсөөлөхийг, бүх хамтрагчдынхаа давуу болон адил талыг ч харж чаддаг болохыг” уриалжээ.

Протестантууд дундаас Назарын Чуулган нь онцгойгоор өсөж чадсан юм. 1998 он гэхэд Назарчуудын тал нь Америк болон Канадад суурьшин амьдрахаа больсон тул 2001 онд Ерөнхий Чуулга Уулзалтад оролцсон төлөөлөгчдийн 41 хувь нь тэдний хоёр дахь хэл англиар ярьж, бусад нь огт ярихаа больсон байлаа. 2009 онд Капе Вердегийн Эугенио Дуарте гэх африк хүн Назарын чуулганы ерөнхий удирдлагын зөвлөлийн даргаар сонгогдсон.

ОЛОН УЛСЫН ҮЙЛЧЛЭЛИЙН ЯЛГАРАХ ОНЦЛОГУУД

Назарын үйлчлэл нь бодлогын хувьд сайнмэдээ түгээхээс гадна нийгмийн үйлчлэл ба боловсролд түлхүү анхаарч байлаа. Соёл дамнасан илгээлтийн ажилчид, мянга мянган пастор, Уэслийн зарчмыг өөрсдийнхөө соёлд түшиглэн нутагшуулан заасан жирийн ажилчдын хамтын ажиллагааны хүчээр Назарын үйлчлэл улам бүр цэцэглэн хөгжсөөр байна.

Хирам Ф.Рейнолдс бол Назарын соёл дамнасан үйлчлэлийг эхлүүлэхэд, түүнчлэн дэлхий даяар хийгдэж буй сайнмэдээний ажлын хүрээнд урсгал чиглэлийн ойлголтыг боловсронгуй болгоход үнэхээр торгон мэдрэмжтэй, нарийн стратеги төлөвлөгөөтэй хандсан хүн юм. 25 жилийн турш ерөнхий удирдлагын зөвлөлд байх үедээ өгч байсан түүний зөвлөгөөнүүдийн ачаар урсгал чиглэлийг эн тэргүүнд тавьсан үйлчлэлүүд боссон байна. 1915 оноос эхлэн Назарын Олон Улсын Илгээлтийн Үйлчлэл (хуучнаар Эмэгтэйчүүдийн Илгээлтийн Нийгэмлэг) санхүүжилт босгон илгээлтийн боловсрол олгох сургалтыг дэлхийн сүм, цуглаануудад зохион байгуулж эхэлжээ.

Назарчууд эртнээсээ өрөвч, энэрэнгүй хүмүүс байсан хийгээд Энэтхэгийн өлсгөлөнд нэрвэгдэгсдэд туслан, асрамжийн газрууд, ганц бие охид, эмэгтэйчүүдэд зориулан амьдрах байр барьж, мөн түүнчлэн хот сууринд амьдардаг архинд донтсон болон гэр оронгүй хүмүүс рүү чиглэсэн үйлчлэлүүдээрээ дамжуулан Бурханы нигүүлслийг гэрчлэн, хүмүүст тусалж байлаа. 1920-иод оны үеэс цуглааны гол үйлчлэл болох нийгмийн үйлчлэл нь эрүүл мэндийн салбар уруу шилжин, Хятад болон Свазиланд, дараа нь Энэтхэг, Папуа Шинэ Гвинейд эмнэлэгүүдийг байгуулав. Назарын эрүүл мэндийн мэргэжилтнүүд нь өвчтөнийг асарч, хагалгаа хийн, сувилагчдыг бэлтгэн, зарим нэн ядуу хэсгийнхэнд зориулсан нүүдлийн эмнэлгүүдийг санхүүжүүлж байлаа.

Төрөлжсөн эмнэлгүүд, тухайлбал, Африкт уяман өвчний эмнэлэг байгуулав. Назарын Энэрэнгүй Үйлсийн Үйлчлэл нь 1980-аад онд байгуулагдаад өдгөөг хүртэл өргөн цар хүрээг хамарсан нийгмийн үйлчлэл болтлоо хүлээн зөвшөөрөгдөж чадсан ба хүүхдийг дэмжих, гамшгийн үед үзүүлэх яаралтай тусламж, ДОХ-ын боловсрол олгох, өнчин хүүхдүүдийг дэмжих, цэвэр усны төслүүд, хүнсний хангамжийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулсаар байгаа билээ.

Назарын хүүхдийн цуглаан болон Библи судлал нь сүм цуглааны нэгээхэн хэсэг байсаар ирсэн бөгөөд Христийн дагалдагчдыг бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. 1905 онд байгуулагдсан Калькутта дахь Найдвар охидын сургуульд суурь боловсрол олгох, бичиг үсэгтэй болгоход нь чуулганы зүгээс хөрөнгө оруулалт хийж байв. Назарын сургуулиуд хүмүүсийг нийгэм, эдийн засаг болон итгэлийн амьдралд бүрэн оролцоотой байхад нь бэлтгэдэг. 20-р зууны дунд үе хүртэл АНУ-ын хамгийн анхны коллежуудын дэргэд бага сургуулиуд болон ахлах сургуулиуд байв.

Назарын үүсгэн байгуулагчид онцгойлон дээд боловсролд хөрөнгө оруулж байсан нь пасторууд болон бусад Христийн ажилчдыг зайлшгүй сургах, нийгэмд ажиллагсдыг хэлбэржүүлэх ёстой хэмээн гүнээ итгэж байсантай нь холбоотой. Олон Улсын Боловсролын Зөвлөлөөс дэлхий даяар дээд боловсрол олгодог Назарын сургуулиудыг жагсаасны дотор Африк, Бразил, Канад, Карибын улсууд, Солонгос, АНУ дахь чөлөөт урлагийн коллеж ба дээд сургуулиуд, дээр нь Библийн коллежууд, дээд сургуулиуд, Энэтхэг, Папуа Шинэ Гвиней дэх сувилагчийн сургуулиуд, мөн Австрали, Коста Рика, Англи, Филиппин, АНУ дахь Теологийн сургуулиуд тус тус багтжээ.

Назарын Чуулган нь цаг хугацааны уртад сүмийн хэлбэрээс дэлхий нийтийн итгэгчдийг хамарсан олон улсын үйлчлэл болтлоо өргөжин тэлсэн билээ. Уэсли уламжлалаас болж Назарчууд өөрсдийгөө таньж мэдэн, “Үндэстнүүдэд Христтэй адилхан дагалдагчдыг бэлтгэх” эрхэм зорилгыг тээгчид болсоор байна.

ҮНДЭСТНҮҮДЭД

ХРИСТИЙН ДАГАЛДАГЧ

БЭЛТГЭХ НЬ

НАЗАРЫН ЧУУЛГАНЫ

ЭРХЭМ ЗОРИЛГО мөн.



ҮНЭТ ЗҮЙЛС

1. БИД ХРИСТИТГЭЛТ ХҮМҮҮС

Бүх Дэлхийн Чуулганы гишүүний хувьд, бид бүх жинхэнэ итгэгчдийн хамт Их Эзэн Есүс Христийг тунхаглаж, Христитгэлийн түүхэн билэгдэл, итгэл үнэмшил болсон Ариун Гурвалыг хүлээн зөвшөөрдөг. Бид Уэслийн Ариун үнэт өвийг эрхэмлэн дээдэлдэг бөгөөд энэ нь Библид бичигдсэн үнэн, учир шалтгаан, ёс уламжлал болон амьдралын туршлага зэргээс итгэлийн мөн чанарыг ойлгох арга зам хэмээн итгэдэг.

Бид бүх итгэгчидтэй нэгдэн, хамтдаа Их Эзэн Есүс Христийг тунхагладаг. Бурхан тэнгэрлэг хайраараа бүх хүмүүсийн гэм нүглийг уучилж, тэдэнтэй харилцаагаа сэргээдэг гэдэгт бид итгэдэг. Бурхантай эвлэрснээрээ бид хоорондоо ч эвлэрч, Бурханаар хайрлагдсанахаа адил бид бас нэг нэгнээ хайрлан, Бурхан бидний гэм нүглийг уучилсны адил бид ч бас бусдыгаа уучилна гэдэгт итгэдэг. Бид өөрсдийн амьдралаараа Христийн зан чанарыг үлгэрлэн харуулна гэдэгтээ итгэдэг. Бурханы Үг бол учир шалтгаан, ёс уламжлал, амьдралын туршлагаар маань батлагдсан сүнслэг үнэний тулгуур үндэс болдог гэдэгт бид итгэдэг.

Бид бүх итгэгчидтэй нэгдэн, хамтдаа Их Эзэн Есүс Христийг тунхагладаг.

Нисений сургаалд хэлснээр Есүс Христ бол цор ганц, ариун, бүх дэлхийн болон элчийн Чуулганы Эзэн мөн. Есүс Христийн дотор, Ариун Сүнсээр дамжуулан, Бурхан Эцэг гэм нүглийг уучлан, ертөнцийг Өөртэйгээ эвлэрүүлдэг. Бурханы энэхүү бэлгийг итгэлээрээ хүлээн авсан хүмүүс Бурханы ард түмэн болдог. Христийн дотор уучлагдан, эвлэрүүлэгдсэнээр бид бусдыг ч мөн уучлан тэдэнтэй эвлэрдэг. Ийм замаар бид Христийн Чуулган ба Бие нь болж, тэрхүү Биеийн эв нэгдлийг илтгэн харуулдаг. Христийн нэгэн Бие болсноороо бид “нэг Эзэн, нэг Итгэл, нэг Баптисм”-тай болдог. Бид Христийн Чуулганы эв нэгдлийг зөвхөн тунхаглаад зогсохгүй үүнийгээ бүхий л талаар сахин хамгаалахаар чармайн хичээдэг билээ. (Ефес 4:5)

2. БИД АРИУН ХҮМҮҮС

Өөрөө ариун Нэгэн болох Бурхан биднийг ариун амьдрал уруу дууддаг. Ариун Сүнс бидний дотор нигүүлслийн хоёр дахь ажил буюу “бүрэн төгс ариусал” болон, “Ариун сүнсний баптисм”-аа хийхээр эрэн хайж байгаа бөгөөд биднийг бүх гэмээс цэвэрлэж, Бурханы дүр төрхийн дагуу шинэчилж, Бурхан Эзэнээ бүх зүрх, сэтгэл, оюун ухаан, бүх хүчээрээ хайрлах, мөн хөршөө өөрийн адил хайрлаж, Христийн зан чанарыг өөрөөсөө гаргаж амьдрахыг хүсдэг гэдэгт бид итгэдэг. Итгэгчдийн ариун амьдрал гэдэг нь Христийг даган дуурайх амьдрал юм.

Энэ нь биднийг Бурханы дүр төрхийн дагуу байгуулж, бидний дотор Христийн зан чанарыг бүтээдэг Ариун Сүнсний ажил юм.

Бид Бурханыг магтан хүндэлж, Түүнийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчээрээ хайрлахаар Бичээсээр дуудагдаж, нигүүлслээр хөтлөгдсөн бөгөөд хөршөө өөрийн адил хайрлаж, өөрсдийгөө бүтнээр нь, дүүрнээр нь Бурханд зориулан, “бүрэн төгсөөр ариусгагдаж чадна” гэдэгтээ итгэдэг.

Ариун Сүнс биднийг зэмлэдэг, цэвэршүүлдэг, дүүргэдэг бөгөөд Бурхан биднийг нигүүлслээрээ бусдад хайртай, сүнслэг сахилга баттай, цэвэр ёс зүйтэй, ухамсартай, өрөвч бөгөөд зөвт хүмүүс болгон өдрөөс өдөрт өөрчлөн шинэчилдэг гэдэгт итгэдэг. Энэ бол биднийг Бурханы дүр төрхөөр

өөрчилж, бидний дотор Христийн зан чанарыг бий болгож буй Ариун Сүнсний ажил юм.

Оргүй хоосныг оршин буй бодит зүйл болгон дууддаг Бүтээгч, Эцэг Бурханд бид итгэдэг. Нэгэн цагт бид оршин байгаагүй бөгөөд харин Бурхан биднийг бүтээж, Өөрийнхөө төлөө бий болгож, Өөртэйгээ ижил дүр төрхөөр биднийг хэлбэржүүлэн урласан билээ. *“Учир нь Би бол та нарын Бурхан ЭЗЭН. Тиймээс өөрсдийгөө ариусгаж, ариун бай. Учир нь Би ариун билээ”* (Левит 11:44а) гэсэнчлэн бид Бурханы дүр төрхийг харуулахаар бүтээгдсэн болно.

3. БИД ҮЙЛЧЛЭХ ХАРААТАЙ ХҮМҮҮС

Бид Христийн дуудлагад хариулж, Христ Эзэнийг гэрчилж, бүх дэлхий рүү явахаар Ариун Сүнсээр хүчирхэгжүүлэгдсэн, Христ бол Эзэн гэдгийг гэрчлэн тунхаглаж, Бурхантай хамтран Чуулганыг байгуулж, Түүний Хаанчлалыг (Матай 28:19-20, 2Коринт 6:1) тэлэхээр илгээгдсэн хүмүүс билээ. Бидний үйлчлэл (а) магтаал хүндэтгэлээр эхэлж, (б) дэлхийд сайнмэдээг тунхаглан, бусдад энэрэнгүй сэтгэлээр тусалж, (в) дагалдагч бэлтгэх замаар итгэгчдийг Христ дотор төлөвшүүлж, (г) Христэд дээд боловсролоор дамжуулан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг Христийн үйлчлэлд бэлтгэх зорилготой.

А. МАГТААЛЫН ҮЙЛЧЛЭЛ

Дэлхий дээрх Чуулганы үйлчлэл хүндэтгэл магтаалаар эхэлдэг. Бид Бурханыг хүндэтгэхээр хамтдаа цуглахдаа магтан дуулж, Библи уншиж, өргөл, аравны нэгээ өргөн, залбирч, номлол сонсож, баптисм хүртэж, Их Эзэний Ариун Зоогийг хуваалцан байхдаа Бурханы хүмүүс байхын утга учрыг маш тодорхой мэддэг. Дэлхий даяар хийгдэж буй Бурханы ажилд итгэх бидний итгэл нь хамгийн түрүүнд чуулгануудын хүндэтгэл магтаалаар хэлбэрждэг бөгөөд бидний үйлчлэл бол шинэ итгэгчдийг хүлээн авч, тэдэнтэй нөхөрлөн, шинэ хүндэтгэл магтаалын цуглааныг бий болгоход оршдог гэдгийг ойлгох явдал юм.

Хүндэтгэл магтаал нь Бурханыг хайрлах бидний хайрын хамгийн дээд илэрхийлэл юм.

Энэ бол Бурхан-төвт хүндэтгэл бөгөөд нигүүлсэл ба өршөөлөөрөө биднийг авардаг Нэгэнийг дээдлэн хүндлэх хэлбэр юм. Хүндэтгэл магтаалын гол утга учир нь өөртөө төвлөрдөг эсвэл өөрсдийгөө алдаршуулдаг биш харин өөрсдийгөө зориулдаг, өөрсдийгөө өргөдөг Бурханы хүмүүсийн цуглардаг нутгийн сүм байхад оршино. Бурханы хайраар дүүрэн, дуулгавартайгаар Бурханд үйлчилдэг сүмийг хүндэтгэн магтдаг чуулган гэж хэлнэ.

Б. ЭНЭРЛИЙН ҮЙЛЧЛЭЛ БА САЙНМЭДЭЭ

Бурханы төлөө зориулагдсан хүмүүс бид төөрөлдсөн нэгнүүдэд Түүний хайрыг, ядуус болон зовогсдод Түүний энэрэнгүй сэтгэлийг хуваалцдаг. Их Эзэний агуу тушаал (Матай 22:36-40) болон Их Эзэний Агуу Захирамж нь (Матай 28:19-20) дэлхийг сайнмэдээ, энэрэнгүй сэтгэл ба зөвт байдлаар нэгтгэх үйлсэд биднийг замчилдаг.

Төгсгөл хүртэл бид хүмүүсийг итгэлд уриалан, гачигдагсдад тусалж, шударга бус явдал, дарангуйллын эсрэг бат зогсож, Бурханы бүтээлийн нөөцийг хадгалан хамгаалахын төлөө ажиллан, Эзэний нэрээр дуудагдсан хэнтэй ч нөхөрлөхөд өөрсдийгөө зориулах ёстой билээ.

Чуулган дэлхий дээрх эдгээр үйлчлэлүүдээрээ дамжуулан Бурханы хайрыг харуулж байна. Библийн түүхүүд бол Есүс Христээр дамжуулан ертөнцийг Өөртэйгээ эвлэрүүлсэн Бурханы түүх юм. (2Коринт 5:16-21) Бурхантай хамтран сайнмэдээ, энэрэнгүй үйлс ба шударга ёсны төлөөх үйлчлэлд оролцуулахын тулд Чуулганыг илгээсэн.

В. ДАГАЛДАГЧ БЭЛТГЭХ БИДНИЙ ЗОРИЛГО

Бид Есүсийн дагалдагч байхын тулд өөрсдийгөө зориулдаг төдийгүй бусдыг ч мөн Түүний дагалдагч болохыг уриалдаг. Ийм учраас бид (хүүхдийн цуглаан, Библи судлал, эсийн бүлгүүд гэх мэт) бүхий л арга замаар үйлчлэн, эдгээр үйлчлэлүүдээр дамжуулан итгэгчдийг Христитгэлийн талаар илүү ойлголттой болж, өөр хоорондоо болон Бурхантай харилцах харилцаандаа өсөхөд нь хөхиүлэн урамшуулдаг. Дагалдагч хүн өөрийгөө дуулгавартайгаар Бурханд зориулж, итгэлийн сахилга баттай байх ёстой гэж бид ойлгодог. Нэг нэгэндээ тусалж, бие биенээ харилцан дэмжин, ариунаар амьдарч, Христийн дотор нөхөрлөж, хайрлахаас өөр өргүй байх ёстой гэдэгт мөн итгэдэг. Жон Уэсли хэлэхдээ

“Бид нэг нэгнийхээ гарыг тэнхрүүлэхийн тулд Бурхан биднийг бие биенд маань өгчээ” гэжээ.

Ариун Сүнс биднийг алгуураар Христийн төлөвшилд авчирдаг арга замыг дагалдагч бэлтгэх гэнэ.

Христэд итгэн дагах нь бидний амьдралын замнал билээ. Өөрөөр хэлбэл, Бурхан биднийг энэ дэлхийд хэрхэн амьдруулахыг хүсч байгаад суралцах үйл явц юм.

Бид Бурханы Үгийг дуулгавартай дагахаар өөрсдийгөө зориулахад, нэг нэгэндээ хариуцлагатай хандахад суралцсанаар итгэлийн амьдралын жинхэнэ баяр хөөрийг, итгэлийн эрх чөлөөний утга учрыг ойлгож эхэлдэг. Дагалдагч байна гэдэг нь хүний хүчин чармайлт биш, дүрэм журамд захирагдах ч биш. Харин Ариун Сүнс биднийг аажмаар Христ дотор төлөвшүүлэхийг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл дагалдагч байснаараа бид Христийн зан чанарыг харуулсан хүмүүс болдог гэсэн үг. Дагалдагчийн эцсийн зорилго бол Есүс Христ шиг болж өөрчлөгдөн төлөвших юм. (2Коринт 3:18)

Г. ХРИСТЭЧ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧЛЭЛ

Христэч боловсролоор дамжуулан эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг Христийн үйлчлэлд бэлтгэхийг бид зорилгоо болгодог. Мөн сургалтууд, Библийн сургууль, коллеж, их, дээд сургуулиудад суралцагсдад мэдлэг олгох, Христтэй адил зан чанартай болгон төлөвшүүлэх, дэлхий даяар Бурханы дуудлагыг биелүүлэхэд нь сүм чуулгануудын удирдагчдыг хүчирхэгжүүлэхийг зорьдог.

Христэч дээд боловсрол бол Назарын Чуулганы үйлчлэлийн цөм гэж хэлж болно. Назарын Чуулганы эхэн үеүдэд Уэслийн Ариун Байдлын шинэчлэлийг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэх үйлсэд Бурханы эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг удирдлагын түвшинд бэлдэх зорилгоор Христэч дээд боловсролын сургуулиудыг байгуулж байжээ. Бид үргэлжлүүлэн дэлхий дахинаа сургалт, Библийн сургууль, коллеж, их, дээд сургуулиудын сүлжээ бүхий Христэч дээд боловсролд анхаарсаар байна.

ИРЦГЭЭ, ИХ ЭЗЭНД

БАЯРЛАН ДУУЛАГТУН

АВРАЛЫН ХАДАНД

ЧАНГААР ХАШГИРЦГААЯ

ИХ ЭЗЭН

ЕСҮС ХРИСТ



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бүх үндэстнийг Христийн дагалдагч болгох нь Назарын Чуулганы эрхэм зорилго. Бид Агуу Захирамжийн дагуух чуулган. (Матай 28:19-20) Бид энэ дэлхий дэх итгэлийн гэр бүл бөгөөд Есүс Христ доторх амьдралын Сайнмэдээг хаа сайгүй тунхаглаж, бичээс дэх ариун байдлын (Христийг дуурайн амьдрах) мэдээг газар сайгүй түгээн дэлгэрүүлэхээр дуудагдсан хүмүүс билээ.


Назарын Чуулган Есүс Христийг амьдралынхаа Эзэн болгон хүлээн авсан хүн бүртэй хамтран, Христийн нөхөрлөлийг хуваалцаж, магтаал, номлол, сургалт, бусдын төлөөх үйлчлэлээр дамжуулан бие биенээ итгэл дотор хүчирхэгжүүлэх арга замуудыг эрэн хайдаг.

Бид Христийг дуурайн амьдрахын төлөө өөрсдийгөө зориулаад зогсохгүй Есүс Христийн өрөвч, энэрэнгүй сэтгэлийг бүх хүмүүст харуулахын төлөө, хичээнгүйлэн зүтгэдэг.

Хэдийгээр сүмийн гол зорилго нь Бурханыг алдаршуулах ч гэлээ ертөнцийг Өөртэйгээ эвлэрүүлэх Түүний ажилд идэвхтэйгээр оролцохоор бид дуудагдсан. Эрхэм зорилгын дотор сайнмэдээ, ариусгал, дагалдагч бэлтгэх, энэрэнгүй үйлс зэрэг бидний үйлчлэлийн түүхэн суурь ажлууд багтдаг. Ариун байдлын мөн чанар бол Христийг даган дуурайх явдал юм.

Гэр бүл, ажлын газар, орон нутаг, хөдөө тосгон руу төдийгүй бусад хот, улс орон руу илгээгддэг хүмүүс бол Назарчууд. Одоо ч дэлхийн эргэн тойрноос илгээлтийн эздийг илгээсээр байна.

Бурхан эгэл жирийн хүнээр ер бусын ажлыг хийлгүүлж, Ариун Сүнсээр удирдуулсан хүнээр боломжгүйг ч боломжтой болгуулахаар дуудсаар байна.



НАЗАРЫН ОНЦЛОГ

2013 оны Ерөнхий Чуулга уулзалтаар Ерөнхий Удирдлагын Зөвлөлөөс Назарын Чуулганы долоон онцлогийг тодорхойлжээ. Үүнд:

1. Утга учиртай магтаал
2. Теологийн уялдаа холбоо
3. Сайнмэдээг тунхаглах чин хүсэл
4. Зорилготойгоор дагалдагч бэлтгэх
5. Чуулганы хөгжил
6. Өөрчлөгдсөн удирдагч
7. Зорилготой энэрлийн үйлс

Хэдийгээр “Үндэстнүүдэд Христийн дагалдагч бэлтгэх” гэсэн бидний үйлчлэлийг, мөн “Христитгэл, ариун байдал ба үйлчлэл”-ийн маань үнэт өвийг эдгээр тодорхойлолтууд бүрэн гүйцэт илэрхийлж чадахгүй ч бидний итгэл Назарын Чуулган нэг бүрийн онцлогийг илтгэн харуулж, Назарчуудаар дамжуулан газар сайгүй тод томруунаар харагдаж байдаг юм. Цаашдын ирээдүйнхээ төлөө чуулганы удирдагчдаасаа төдийгүй бүх Назарчуудаасаа эдгээр онцлог шинжүүдийг билэгдэн дээдлэхийг бид уриалдаг. Цаг хугацаа улирах тусам тэд хэрхэн дэлхийн чуулган болон бодитоор хөгжихийг харах үлдлээ.

1. Утга учиртай Магтаал

Магтахаар дуудагдсан

*Ирэгтүн, ЭЗЭНд баясалтайгаар дуулцгаан,
Авралынхаа хаданд баяртайгаар хашхирцгаая.
Түүний өмнө талархалтайгаар ирж,
Түүнд дууллуудаар баяртайгаар хашхирцгаая.
ЭЗЭН бол аугаа их Бурхан бөгөөд
Бүх бурхдын дээд аугаа Хаан юм.
Дэлхийн гүн газрууд Түүний гарт байдаг бөгөөд
Уулсын шовх оройнууд ч бас Түүнийх.
Далай ч Түүнийх. Учир нь Тэрээр түүнийг бүтээсэн Нэгэн бөгөөд
Түүний мутар хуурай газрыг ч дүрсэнд оруулсан.
Ирэгтүн, мөргөж, бөхийн,
Биднийг бүтээгч ЭЗЭНий өмнө өвдөг сөгдөцгөөе.
Учир нь ЭЗЭН бол бидний Бурхан бөгөөд
Бид Түүний хариулдаг хүмүүс, Түүний мутрын хонин сүрэг юм.
Дуулал 95:1-7а*

Бурханд өргөх хүндэтгэл магтаалаар бид Түүнийг Авралын хад, агуу Бурхан, бүх бурхдын дээд агуу Хаан, бүхнийг бүтээсэн Бүтээгч болон өөрийн хүмүүстээ санаа тавьдаг Хоньчин гэдгийг итгэлтэйгээр хэлэх болно.

А. Эзэн Есүсийн дагалдагч нар Түүнтэй хамт амьдарч, харилцаж, бусдад үйлчилж байсан.

- Эзэн Есүс дагалдагч нараа дэлхийд үйлчлүүлэхээр илгээсэн. (Матай 10)
- Тэр тэднийг хожим Ариун Сүнсээр дүүргэгдэнэ гэж хэлсэн. Тэднийг дээд өрөөнд байхад Есүсийн амласан ёсоор Ариун Сүнс ирсэн. (Үйлс 2)
- Дагалдагч нар нь дэлхийд үйлчилж эхэлснээр Бурханы элчин сайдууд болов.
- Тэд эвлэрүүллийн үйлчлэлийн төлөө эвлэрлийн мэдээг авчирсан. (2Коринт 5:11-21)
- Паул үүнийг хамгийн сайн гэж хэлсэн. “Иймээс бид Христийн төлөөх элчин сайд нар юм. Бурхан биднээр дамжуулж ятгаж байгаачлан бид Христийн төлөө та нараас гуйя. Бурхантай эвлэрцгээ. Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм. Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм” (2Коринт 5:20-21)

Б.Эзэн Есүс дагалдагч нартаа Агуу Захирамжийг биелүүлэхийг тушаасан.

“Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав” (Матай 28:19-20)

Анхны чуулган энэхүү тушаалыг биелүүлэхээр даруй эхэлсэн ба учир утгатай магтаалыг анх Антиохын сүмд хэрэгжүүлсэн байна. Үйлс 13:1-4

В. Бид Сүнсээр удирдуулан мацаг барих, залбирах зэргээр сахилга батаа дадлагажуулахыг *утга учиртай магтаал* гэж ойлгож болно.

- Ариун Сүнс бусдыг итгэгч болгохоор тэднийг илгээсэн.
- Энэ нь магтаал дотор болсон.
- Магтаал нь биднийг зоригжуулж, Бурханы хүчийг амьдралд маань цутгадаг.
- Магтаал нь бидний амьдралыг Христийн зүйлс рүү чиглүүлдэг. Түүнчлэн Бурханаар хэрэглэгдсэн биднийг Есүсийн дүр төрхийн дагуу хэлбэржүүлдэг, бүх итгэгчдийг сахилгажуулдаг сүнслэг хүч мөн.
- Бид гэртээ ч, сүмдээ ч байнга магтаж байх ёстой.

Г. *Утга учиртай магтсанаар* сүмийн үйлчлэл дотор Бурхан Өөрийн арга замаар хөдлөх боломжтой болдог.

- Эртний чуулганууд семинар сургалт хийдэг арга замаар ажилладаггүй байсан.
- Харин тэднийг хамтдаа цуглан магтахад нь Бурхан тэдний дунд чөлөөтэйгээр ажилладаг байжээ.
- Бид өөрсдийнхөө төлөвлөгөөг зогсоож, Бурханы төлөвлөгөө бидний дунд бүрэн төгс биелэхийг зөвшөөрөх ёстой.
- Бид Бурханыг хүсэн хүлээж байгаа учраас магтаалаар дамжуулан Бурханд чөлөөтэй ажиллах орон зайг нь гаргаж өгдөг.
- Бурхан Өөрийнхөө цаг хугацаанд, Өөрийнхөө арга замаар хүмүүст ойлгуулж, тэднийг хөдөлгөж, тэдэнд хүрч, аварч, тэднийг ариусгахыг бид Түүнд зөвшөөрөх ёстой.

- Бид Түүнийг магтан хүндлэхээр цуглах бүртээ Бурхан бидэнтэй уулзаж, бидний дунд ажиллах болно гэсэн эмээлт, хүлээлттэй ирэх ёстой.
- Долоо хоног бүр цуглахдаа зөвхөн Бурхан Өөрөө л хүссэн арга замаараа ажиллаж чадна гэдэгт бид итгэх ёстой. Байдаг л нэг зуршил болсон цугларалтад хэзээ ч сэтгэл ханаж болохгүй.
- Бурханы Сүнсээр хүчирхэгжин өсөхийн тулд Бурханы хүүхдүүд долоо хоног бүр хамтдаа цуглах ёстой.
- Бурханы Сүнснээс өөр юу ч хүний сүнсийг тэнхрүүлж чадахгүй.
- Утга учиртай, нэгдмэл магтаал дотор л энэ бүх зүйл хамгийн сайнаар биелэх боломжтой.

2. Теологийн Уялдаа холбоо

А. Христийн томоохон чуулгануудад Назарынхны дуу хоолой нь хүрэх ёстой.

- Теологийн хувьд бид ямар үзэл баримтлалтай талаар хэлдэг.
- Бид юунд баттай итгэдэг, юу биднийг хөдөлгөдөг, итгэлийн амьдралдаа ч тэр, өдөр тутмынхаа энгийн амьдралдаа ч тэр бид хэрхэн амьдардгийг хэлдэг.

Б. Эдгээр нь бидний теологийн уялдаатай байдлын эх сурвалж юм.

- Бичээс: Ариун бичээсүүд нь Христ доторх бидний нэр төрийн тулгуур ба амин чухал суурь гэдэгт бид итгэдэг.
- Христитгэлт уламжлал: Христийн янз бүрийн ёс уламжлалаар дамжуулан 2000 жилийн түүхтэй ортодоксийн сургаалыг бид заадаг.
- Учир шалтгаан: Бурханы Сүнс бидний оюун ухаанаар дамжуулан ажиллаж, ялган таних ухааныг өгдөг гэдэгт бид итгэдэг.
- Хувийн туршлага: Христийг дагадаг хувь хүн, бүлэг хүмүүсийн амьдрал дотор, мөн тэдний амьдралаар дамжуулан Бурхан ажлаа хийдэг гэдэгт бид итгэдэг.



Теологийн хамаарлын эх сурвалжууд

В. Дээрх хамаарлууд нь биднийг теологийн хувьд нягт уялдаатай болохыг харуулна.

- Бид Христитгэлтнүүд
Бид Есүс Христийг Бурханы Хүү гэдэгт бат итгэдэг.
Христ бол Ариун Гурвалын хоёр дахь бодгаль мөн гэдэгт бид бат итгэдэг.
Бид ортодокс итгэл үнэмшил болон Христийн чуулганы уламжлалыг баримталдаг.
- Бид Протестантууд
Аврагдсан бид зөвхөн итгэлээр дамжуулан нигүүлслээр зөвтгөгдсөн гэдэгтээ итгэдэг.
Бид Бичээсийн эрх мэдлийг өндөрт өргөмжилдөг.
Итгэгчид бол тахилчид гэдэгт бид итгэдэг.
Сургаал бол магтаал хүндэтгэлийн төв гэдэгт бид итгэдэг ба тиймээс ч сүмийн голд индрээ байрлуулдаг.
Христийн бие болсон бүх итгэгчдэд Сүнслэг бэлгүүд өгөгдсөн гэдэгт бид итгэдэг.
- Бид сайнмэдээ тунхаглагчид
Гэмийн уучлал болон Христтэй адил болж өөрчлөгдсөн зан чанараараа дамжуулан Есүс Христтэй хувьчлан харилцах боломжтой бөгөөд харилцах зайлшгүй шаардлагатай гэдэгт бид итгэдэг.
Бид амьдралын хэв маягаа өөрчлөн, итгэлээ гэрчлэх боломжтой гэдэгт итгэдэг.
- Бид Уэсличүүд
Бүх теологи “Бурхан бол хайр” гэдгийг баталдаг Бурханы мөн чанарт бид итгэдэг. (1Иохан 4:8)
Хүмүүс Бурхантай бодит харилцаатай байх сонголт хийх эрх чөлөөтэй гэдэгт итгэдэг.
Бурханы нигүүлсэл ба өршөөл хүн төрөлхтөн дээр байдаг гэдэгт бид итгэдэг.
Бурханы нигүүлсэл бидний өмнө явж, биднийг гэм нүгэлд живэхээс хамгаалан, Бурхан уруу авчирдаг гэдэгт бид итгэдэг.
Бурхан хүмүүсээ бэдэрч, чөлөөлж, хамгаалж, ариусган, хангалттай нигүүлслээрээ биднийг Бурханы хүүхдүүд болгон авч, итгэлийн замд маань ялалтуудыг өгдөгт бид итгэдэг.
Гэмийн хүчийг нурааж, гэмтэй нэгнийг Эзэн Бурханаа сэтгэл

зүрхнээсээ хайрладаг, Түүнээс эмээх сэтгэлтэй Бурханы хүүхэд болгон өөрчилдөг хүч бол нигүүлслийн хүч гэдэгт бид итгэдэг.

- Ариун байдал болон ариусгал бидний энэ амьдралд бодитоор байдаг гэдэгт бид итгэдэг.
- Сүнсний гэрчлэлд бид итгэдэг.

Гэм нүглүүд нь Бурханаар уучлагдсанд хүмүүс эргэлздэггүй гэдэгт бид итгэдэг бөгөөд Есүс Христийн цус бидний өнгөрсөн амьдралын гэм нүглийг хучиж, өдөр бүр бидэнд ялалтыг өгдөг гэдэгт бид баттай итгэдэг.

Өдөр тутмын амьдралдаа шийдвэр гаргахад нь итгэгч хүн болгонд Бурханаар удирдуулах боломжийг олгодог Сүнсний хөтлөлд бид итгэдэг.

Д. Ариун амьдралын дөрвөн чухал ойлголтод бид итгэдэг.

- Христийг даган дуурайх гэдэг нь өдөр бүр Есүсийн дүр төрхийн дагуу Ариун Сүнсний хүчээр өөрчлөгдөж, өөрсдийнхөө дотор Бурханы ажил чөлөөтэйгээр хийгдэхийг зөвшөөрөхийг хэлнэ. *“Тиймээс хэрэв Христ дотор ямар нэгэн дэмжлэг байгаа бол, хэрэв хайрын тайвшрал байгаа бол, хэрэв Сүнсний нөхөрлөл байгаа бол, энэрэнгүй болоод өрөвчхөн сэтгэл байгаа бол, адил сэтгэж, адил хайртай байж, сэтгэлээрээ нэгдэн, нэгэн бодолтой байж, намайг гүйцэд баярлуул”* (Филиппой 2:1-2)
- Амьдралын хэв маяг гэж ариун зорилгын дагуу энэ дэлхийд Бурханы ажил хийгдэх боломжийг тавина гэсэн үг. *“Би Танаас тэднийг ертөнцөөс аваач гэж гуйхгүй, харин тэднийг муугаас хамгаалаач гэж гуйж байна. Би ертөнцийнх биш адил тэд бас ертөнцийнх биш. Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мөн”* (Иохан 17:15 -17)
- Сорилт болон Сонгох Хүч гэж донтолт, махан биеийн уруу татлага эсвэл хорон муугийн довтолгоонд өртөхгүй байх чадвартай байж харин Бурханы хүчээр ариун амьдралаар амьдарч чаддаг болохыг хэлнэ. *“Та нарын зүрхний мэлмийг гийгүүлэх болтугай! Ийнхүү та нар дуудлагын найдварыг хийгээд ариун хүмүүс дотор Түүний өв дэх алдрын баялгийг, мөн итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын хэмжээлшгүй сүр жавхланг мэдэх болтугай. Энэ хүч нь Түүний чадлын хүчний нөлөө билээ. Тэрээр Христ дотор энэ л хүчээр*

нөлөөлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад тэнгэрт Өөрийн баруун гарт залж” (Ефес 1:18-20)

- Сүнсний үр жимс – Бурханы төгс хайрын илэрхийлэл нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, эелдэг байдал, даруу зан, итгэлтэй байдал, өөрийгөө захирах чадвар юм. *“Хайрын дотор айдас байдаггүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлуулна. Учир нь айдас ял байдаг. Айдаг нэгэн бол хайрын дотор төгс болгогдоогүй байна” (1Иохан 4:18)*

Е. Хэвлэл мэдээллийн хувьд төвийг сахисан байр суурьтай байхыг бид чухалчилдаг. Бид талуудад тулгарсан асуудлуудад хэт нэг талыг баримтлахаас зайлсхийдэг. Мөн хэт хувийн шинжтэй асуудлуудад оролцохоос зайлсхийж, илүүтэйгээр аль болох төвийг сахисан байр сууринаас хандахыг эрхэмлэдэг.

3. Сайнмэдээг тунхаглах чин хүсэл

Сайнмэдээг тунхаглах чин хүсэлтэй байх нь Есүс Эзэний хайр ба хүн төрөлхтний төлөөх Түүний нигүүлсэлд үзүүлж буй бидний хариу үйлдэл юм. Назарын чуулган өөрөө сайнмэдээ тарааж эхэлсэн. Бидний зүрх сэтгэл энэ л зүйлийн төлөө үргэлжлэн шатсаар байх болно. Назарын Чуулганы анхны ерөнхий удирдлагын зөвлөлийн дарга Файнис Бреси хэлэхдээ, “Бид өөрсдийнхөө хүлээн авсан сайнмэдээг хүн болгонд яг тэр чигээр нь дамжуулж өгөх өртэй” гэжээ. Есүс Христэд авралын итгэл байдаг гэдгийг мэдүүлэхийн тулд бид хүмүүст туслах үйлсэд анхаарлаа хандуулдаг юм.

А. Сайнмэдээг тууштайгаар тунхаглахыг Есүс Эзэн үлгэрлэн харуулсан.

- *“Хүмүүсийг хараад Тэр өрөвджээ. Учир нь тэд хоньчингүй хонин сүрэг мэт тарж, туйлдсан байлаа. Тэгээд Тэр шавь нартаа, “Ургац үнэндээ арвин боловч ажилчид нь цөөн байна. Тиймээс ургацын Эзэнээс ургацандаа ажилчдыг явуулахыг залбиран гуйцгаа гэж айлдав”” (Матай 9:36-38)*
- *“Та нар “Ургац хураалт болтол дөрвөн сар байна” гэж хэлдэг биш үү? Үзэгтүн, Би та нарт хэлье. Хараагаа дээшлүүлж, талбайг харагтун. Учир нь талбай цайрч хураалтанд бэлэн болжээ”” (Иохан 4:35)*

Б. Сайнмэдээг тунхаглах нь Есүс Эзэний тушаал байсан.

- “Есүс тэдэнд, “Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагтун”” (Марк 16:15)
- “Есүс тэдэнд хандаж, “Христ зовлон эдэлж, гурав дахь өдрөө үхэгсдээс амилах болно. Иерусалимаас эхлээд бүх үндэстэнд Түүний нэрээр нүглийн уучлалын гэмшил тунхаглагдах ёстой” гэж бичигдсэн юм”” (Лук 24:46-47)

В. Сайнмэдээ тунхаглах ажил Эзэн Есүсээс эхтэй.

- “Хаанчлалын энэхүү сайн мэдээ бүх үндэстэнд гэрчлэл болж дэлхий даяар тунхаглагдана. Тэгээд төгсгөл ирнэ” (Матай 24:14)
- “Хулгайч зөвхөн хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм” (Иохан 10:10)

Г. Сайнмэдээг тунхаглахад Ариун Сүнс хүчийг өгдөг.

- Ариун Сүнс бидэнд хувьд маань болон нийтэд нь ариунаар амьдарч, ариунаар гэрчлэх хүчийг өгдөг.
- “Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв” (Үйлс 1:8)

Д. Сайнмэдээ тунхаглах ажил Ариун Сүнсээр хийгддэг.

- Бидний доторх Түүний амьдрал нь бидний баталгаа ба үр дүн юм.
- “Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм. Эдгээрийн эсрэг хууль гэж байдаггүй юм” (Галат 5:22-23)

Е. Сайнмэдээ нь хувь хүнд болон сүм чуулганд шинэ амьдрал, шинэ эрч хүчийг өгдөг.

- “Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна” (2Коринт 5:17)
- Аврагдсан хүмүүсийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байлаа.

Ё. Сайнмэдээ тунхаглана гэдэг нь бид Есүс Эзэнд дуулгавартай байгаагийн шинж.

- Сайнмэдээний хүчээр өөрчлөгдсөн, хэний ч эсэргүүцэж чадахгүй нотолгоо бол Паулын амьдрал юм.
- Тэрээр гэрчлэлүүдийнхээ нэгэнд, *“Грекчүүд болон бусад үндэстнүүд, мэргэн болон мунхаг хүмүүсийн хэн хэнд нь би өртэй. Тиймд миний хувьд, Ромд байгаа та нарт ч мөн сайн мэдээг тунхаглахыг маш их хүсэж байна. Би сайн мэдээнээс ичихгүй. Яагаад гэвэл тэр нь итгэгч хүн бүрийг, юуны түрүүнд Иудей, мөн түүнчлэн Грек хүнийг авралд хүргэх Бурханы хүч мөн”* гэжээ. (Ром 1:14-16)

Ж. Агуу захирамжийг биелүүлэх нь Христийн төлөөх бидний чин зүрхний гүн хүсэл мөн. (Матай 28:19-20) Чадавхжуулах сургалтууд маань дараах үр дүнг гаргадаг:

- Эдгээрийн үр дүнд, хүн бүр Христийг таньж мэдэх болно.
- Үүнчлэн, ур чадвар, арга барилын хувьд хичнээн бэлэг авьяас тааруу байсан ч хүн бүр Христийг шийдэмгийгээр, тууштайгаар тунхаглах ёстой.

З. Сайнмэдээ биднийг Бурханы Үгийн хүчинд найдан, бусдад авралын сайнмэдээг тунхаглахад зоригжуулдаг.

- Бид итгэлээрээ Библийг судалж, дараа нь Бурханы Үг бидэнд юу хэлдгийг бусдад зааж өгдөг.
- Сайнмэдээний хүч Бурхантай харилцаагаа сэргээх хэрэгтэй олон олон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хөвгүүд, охидын зүрх рүү ярьдаг.
- Есүс Эзэн бидний үлгэр дуурайл юм. *“Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ гэв”* (Лук 19:10) *“Тэрхүү өдрүүдийн нэгэнд Есүс сүм дотор хүмүүст сургаалаа зааж сайн мэдээг дэлгэрүүлэн байхад нь”* (Лук 20:1а)

И. Сайнмэдээ биднийг Христийг илүү таньж мэдэхэд чиглүүлдэг.

- Бидний хэн болох, хэрхэн амьдардгийг илтгэн харуулдаг. Бид амьдрахыг хичнээн ихээр шунан хүсдэг ч энэ нь сайнмэдээ түгээх хүслээс маань илүү байж чадахгүй. Амьдаръя гэвэл сайнмэдээг сонгох хэрэгтэй.
- Энэ нь бидний мэдэж байгаа зүйлийг батлан хэлдэг. Эзэн Есүсийн эдгээсэн сохор хүн гэрчлэхдээ, *“Би нэг л юмыг, урьд нь сохор байснаа, одоо харж байгаагаа л мэдэж байна гэв”* (Иохан 9:25)

- Мөн хувь заяаныхаа төлөө талархах шалгуур болдог. “Үнэгүйгээр авснаа, үнэгүйгээр өг” (Матай 10:8б)

К. Сайнмэдээ бидэнд дагалдагч бэлтгэх чин хүслийг өгдөг.

- Амьдралынхаа туршид б
- ид таньдаг, таньдаггүй олон хүмүүст нөлөөлж, итгэлийн амьдралаа хуваалцахыг хүсдэг.
- Христийн дагалдагч бүр Бурхантай харилцах харилцаандаа тууштай байж, амьдралаасаа урсан, ундарч байдаг итгэлийн гэрчлэлээ бусдад хуваалцдаг байх ёстой.

Л. Сайнмэдээ биднийг бүтээлч байхад тусалдаг.

- Хэрэгслүүд-Есүс Кино, Сайнмэдээний бөмбөг болон Сайнмэдээний шоо гэх мэт байж болно.
- Аргачлалууд-Олон аргачлалууд байх ч, нэг л мэдээ байна.
- Бодлого-Олныг хамарсан, найз нөхөд рүү чиглэсэн, хувь хүн рүү хандсан, жижиг бүлгүүд, хот суурин газрын гэх мэтчилэн олон төлөвлөгөө байж болно.

“Бид өөрсдийнхөө хүлээн авсан сайнмэдээг хүн болгонд яг тэр чигээр нь дамжуулж өгөх өртэй. ”

Файнис Бреси

4. Зорилготойгоор дагалдагч бэлтгэх

А. Есүс Эзэн сүмийг зорилготойгоор дагалдагч бэлтгэдэг байхаар дуудсан.

- “Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав” (Матай 28:19-20)
- Сүмүүд Христийн дагалдагч бэлтгэх өөрийн гэсэн зорилгот арга барилтай байдаг.
- Христийн дагалдагч гэдэг нь Христийн дотор амьдардаг, Христийг дуурайн өөрчлөгдсөн, Түүний хийснийг хийдэг хүмүүс юм. Тэд

өөрсдийгөө үгүйсгэж бүх зүрх сэтгэл, оюун ухаан, хүчээрээ Бурханд дуулгавартай ханддаг. (Марк 12:30, Иохан 15, Лук 9)

- *Зорилгот дагалдагч бэлтгэх* нь бусдыг Христтэй дуулгавартай, дотно харилцааг хөгжүүлэхэд нь тусалдаг. Ийм харилцаатай байж чадвал Христийн Сүнс хүмүүсийн зан байдлыг Өөртэйгээ адилхан болгон өөрчилж, шинэ итгэгчдийн үнэ цэнийг хаанчлалын үнээр сольж, гэр бүлүүд, сүм цуглаан, дэлхий ертөнцөд нөлөөлж чадах Бурханы ажлын эрхэм зорилгод тэднийг татан оролцуулна.

Б. Бид хүмүүсийг Эзэн Есүстэй хувийн харилцаатай болоход нь чиглүүлдэг.

- Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан нигүүлслээр гэмийн уучлал ба өршөөлийг хүлээн авснаар бидний итгэлийн замнал эхэлдэг.
- Христ доторх эдгээр шинэ бүтээлүүд нь дахин төрж, Бурханы гэр бүл болдог.
- Дахин төрснөөр зүрх сэтгэл, амьдралын хэв маяг, Бурханы нигүүлслийн тухай гэрчлэх гэрчлэлүүд өөрчлөгддөг.
- Бид шинэ итгэгчдийг даруй анхааран халамжилж, итгэлийн ахан дүүсийн эгнээндээ нэгтгэн, зөвхөн өөрсдийнхөө төлөө биш, Христ рүү хөтлөн дагуулж, бидний нөлөөлж чадах тэдгээр хүмүүсийн төлөө ч бас аврагдсан гэдгээ хүмүүст анхнаас нь хэлж, заадаг.

Зорилготойгоор дагалдагч бэлтгэх гэдэг нь Христтэй дуулгавартай, дотно харилцааг хөгжүүлэхэд бусдад тусална гэсэн үг. Ийм харилцаатай байж чадвал Христийн Сүнс хүмүүсийн зан байдлыг Өөртэйгээ адилхан болгон өөрчилж, шинэ итгэгчдийн үнэ цэнийг хаанчлалын үнээр сольж, гэр бүлүүд, сүм цуглаан, дэлхий ертөнцөд нөлөөлж чадах Бурханы ажлын эрхэм зорилгод тэднийг татан оролцуулна. Ингэснээр тэд ч мөн дагалдагч бэлтгэгчид болоод зогсохгүй бусдыг бас дагалдагч бэлтгэгчид болгодог.

В. Хүчирхэг номлолуудаар дамжуулан Христийн дагалдагчдыг бэлтгэдэг.

- Христийн дотор итгэлээр өсөхөд пасторууд номлолоороо дамжуулан анхаарлаа хандуулдаг.
- Библи суурьтай номлолуудыг номлохоос гадна хүмүүсийнхээ сүнсний өсөлтөд санаа тавьж, Библиэр өлсдөг нэгэн байхад нь пасторууд анхаардаг.
- Дагалдагч бэлтгэх бүхий л ач холбогдлын тулгуур багана бол Бурханы Үг мөн гэж пасторууд үздэг.
- Сүмийн хүмүүстээ хэрхэн Библи судлах, Үгийн учрыг тунгаан бодож, амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар зааж сургадаг.
- Жилээс жилд пасторууд маань Бичээсийн тэнцвэрт номлолын дэглэмийг хичээнгүйлэн баримталсаар байна.
- Христтэй адил дагалдагчдыг хэлбэржүүлэхийн тулд тэнцвэрт арга замаар хамтдаа цуглаж, бүхнийг амьтай байлгахын тулд пасторууд Бурханы Ариун Сүнсэнд найддаг.
- Есүс олон түмэнд хандан номлож байсан ч дагалдагч нартаа тусад нь нухацтайгаар заадаг байсан.
- Есүс Эзэн хүмүүст ойлгуулахын тулд сургаалт зүйрлэл (түүх) ашиглалгүйгээр ярьдаггүй байв. (Марк 4:34)

Г. Христийн дагалдагчдыг өсгөн, халамжлахын тулд бид хүүхдийн цуглааныг дэмждэг.

- Христийн дагалдагч бэлтгэх зорилгоор Библийг тайлбарлан заах, үгийг амьдралд хэрэгжүүлэх хоёрын аль алиныг нь хүүхдийн багш нар маань заадаг.
- Хүүдийн багш нар маань танхимын сургалтаас гадна итгэлийн талаар залуу итгэгчдийн сонирхсон асуултад хариулж, тэднийг Бурханы нигүүлслээр өсөхөд нь хувьчлан анхаарч ажилладаг.
- Хүүхдийн цуглааны хөтөлбөр нь бага насны хүүхдээс насанд хүрэгчид хүртэлх хүмүүсийг хамруулдаг ба тэдний нас, түвшинд нь тохирсон заах арга бүхий Библийн цогц сургалтын материалуудыг ашигладаг. *“Явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сурга. Тэрээр өтөлсөн ч тэр замыг орхихгүй”* (Сургаалт үгс 22:6)

Д. Бид хариуцлагатай байх үүднээс жижиг бүлгээр Библи судалдаг.

- Жижиг бүлгийн Библи судлал нь шинэ итгэгчдийг багаар болон ганцаарчлан сурах хариуцлагатай болоход нь, итгэлээр төлөвшихөд нь тусалдаг.
- Амьдралд байдаг найз нөхдийн энгийн уулзалтуудаас илүү дээр эрүүл харилцааг жижиг бүлгүүд бий болгодог.
- Ийм цугларалтууд нь Библи судлал болон нийгмийн харилцаа хоёрын нийлэмж бөгөөд биднийг нигүүлслээр өсөхөд хамгийн их ач холбогдолтой харилцаа юм.
- Дагалдагчдын жижиг бүлгүүд нь бүтэн сайнаас бусад өдрүүдийнхээ амьдралд ч гэсэн хамтдаа байх дэм дэмэндээ тогтолцоог хөгжүүлдэг гэж болно.

Е. Сайтар боловсруулсан сүмийн хөтөлбөрөөр дамжуулан Христийн дагалдагчийн сүнсний өсөлтийг бид дэмждэг.

- Библийн асуулт хариултын хөтөлбөр
- Хүүхдийг амьдрах ухаанд сургах үйлчлэл
- Библийн сургуулийн амралтын хөтөлбөрүүд
- Христмас, Үхлээс амилсан баярын хөтөлбөр
- Энэрэнгүй үйлсийн аян
- Дагалдагч бэлтгэх үйлчлэл
- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, ахмад настан, ганц бие, онцгой тусламж хэрэгцээтэй хүмүүс, спортын багууд, бусад ижил төстэй хэрэгцээтэй хүмүүст туслан, тэднийг Христтэй, Түүний чуулгантай холбож өгөх үйлчлэл

Ё. Бид итгэгчдийг итгэлээр өсөж, хөгжих боломжтой бүх арга замыг ашиглахыг уриалдаг.

- Библийг судалж унш, сонсдог хувилбараар ч унш.
- Өдөр бүр залбир.
- Магтан дуу сонс.
- Христитгэлийн тухай ном зохиол унш.
- Таныг Христтэй адил болохын төлөө өдөр бүр хамт залбирах хариуцлагатай хамтрагчийг ол.
- Таныг үнэхээр хайрладаг, хэцүү асуулт асуух хариуцлагатай хамтрагчтай бол.

- Бурхан таны амьдралд юу хийж байгааг өрөөл бусдад байнга хэлдэг байх сахилга батад суралц.

Ж. Бурханы оршихуйг өдөр бүр эрэн хайхад суралцахад нь бид итгэгчдийг урамшуулдаг.

- Бидний Эзэн, Аврагч, Есүс Христтэй харилцдаг хувийн харилцаагаа бид итгэлийн амьдралдаа тод томруунаар харуулж амьдардаг.
- Дагалдагч хүн Христтэй хамт цаг өнгөрөөх тусам Түүнтэй улам адилхан болж өссөөр байдаг.
- Тиймээс бид өдөр бүр Христийн дуу хоолойг сонсож, өдөр бүр Түүний Үгээр хооллон, өдөр бүр Түүний оршихуйд баяр хөөртэй байдаг.
- Христийн дагалдагч хүн Түүнийг цөхрөлтгүйгээр эрэн хайж, зүрхэнд нь хүрсэн хэнтэй ч Түүнийг хуваалцахад ямагт бэлэн байдаг.

Есүстэй улам адилхан болох эсэх нь эрч хүчтэй дагалдагчдын залбирал, Бурханы Үг болон бие биендээ хичээнгүйлэн туслах зэргээс бүрэн шалтгаална.

3. Бид дагалдагчдыг өөрсдөө дагалдагч бэлтгэхийг уриалдаг.

- Их Эзэн бидэнд тушаал өгч, дагалдагч бэлтгэх бүрэн эрхийг өгсөн. (Матай 28:19-20)
- Бид төлөвшсөн итгэгчдийг бусдыг дагалдуулж тэдэнд зөвлөхийг залбиралтайгаар уриалдаг.
- Бид итгэгчдийг бидний дагалдагчдын бүлгийн нэгэн хэсэг болохыг залбиралтайгаар уриалдаг.
- Бид бүгд Эзэнийг эрэн хайж байгаа учраас дагалдагч бэлтгэх энэ үйлсэд өөрсдийн амьдралаараа хөрөнгө оруулалт хийдэг.
- Түүхэн үйл явдалд тулгуурлан жижиг бүлгүүдэд Библи заах арга нь дагалдагчдад Библийн маш бат бэх суурийг тавьж өгдөг учраас тэд ч сурсан зүйлээ цааш нь өөрийнхөө эргэн тойрны хүмүүст хуваалцахад ач холбогдолтой.

5. Чуулганы хөгжил

А. Хамгийн анхны итгэлийн хүмүүсийн нөхөрлөлийг эхлүүлсэн Есүс Христээс Христийн цуглаан эхэлсэн билээ.

- Итгэлийн ахан дүүс Бурханыг магтан хүндлэхээр хамтдаа байнга цугладаг байсан.
- Дараа нь Паул, Барнаб нарын анхны илгээлтийн аяны улмаас шинэ сүмүүд төрөн гарч, өсөн нэмэгдэж эхэлсэн. (Үйлс 13-14)

Б. Хэдийгээр Паул чуулган тарих төлөвлөгөөтэйгээр хоёр дахь удаагаа илгээлтийн аяныг санаачилсан боловч Ариун Сүнс Түүнийг өөр зүгт удирдав. (Үйлс 16)

- Бид Бурханы шинэ алсын хараанд болон Ариун Сүнсний удирдамжид үргэлж нээлттэй байх ёстой.
- Паулд алсын хараа байсан. Энэхүү алсын хараагаа бусдаас эсвэл хүн амын судалгаанаас аваагүй ээ. Харин Бурханы зүрх сэтгэлээс ирсэн юм. Тиймээс бид ч бас шинээр чуулган тарихыг хүсвэл энэ нь Бурханы зүрхнээс ирдэг байх ёстой.
- Паул алсын хараатай хүн байсан. Харин энэ нь хуулбар, стратеги, уриа лоозон, схем зураг, янз бүрийн хөтөлбөр байгаагүй. Паул төөрөлдсөн хүн төрөлхтөн рүү хараалж байсан. Үүнчлэн бидний шинэ сүм тарих хараа зорилго маань ч Есүс Христ хэрэгтэй тэр л хүмүүс рүү маш тодорхой чиглэх ёстой.
- Паул Македони хүний талаар үзэгдэл үзсэн. Тэгэхдээ түүний амьдардаг газар, соёл, ёс заншил, хэл ус, үүх түүхийг нь хүртэл маш тодорхой харжээ. Үүнчлэн, Бурхан бидэнд ч бас маш тодорхойгоор хүмүүс, улс үндэстнийг харуулах болно. Бид Бурханы бидэнд өгсөн хараа зорилгыг олж мэдэн, дуулгавартайгаар биелүүлэх хэрэгтэй.
- Үзэгдэлд Македони хүн зогсож байгааг Паул харсан. Тэр эр Паулыг хүчлээгүй. Бид нүдээрээ ойлголцдог. Сайнмэдээг өвөрлөн зорьж яваа тэр нэгэн бидний хүндлүүштэй, үнэ цэнэтэй нэгэн юм.
- Паул Македони хүнийг зогсоод, “Ирээд бидэнд туслаач!” хэмээн дуудаж байгаагаар харсан. Энэ бол биднийг хөтөлж буй хараа. Бид хот, хөрш, омог, овог, гэр бүлүүд рүү хүрч очих ёстой.

Бид Христийг дэлхийд авчрах ёстой.

В. Сүмийн хөгжлийн төлөө Паулд Өөрийн төлөвлөгөөг мэдүүлсэн шиг тэнгэрлэг удирдагчдыг үргэлжлүүлэн бэлдэхээр Бурханы зорилго ажилласаар байна.

- Македони эр эмэгтэй хүн болж хувирсан. Филиппойн Лидиа гэгч эмэгтэй энэ үйлчлэлд хамгийн тохиромжтой нэгэн болсон.
- Голын эрэг дээр залбирч байсан хэсэг эмэгтэйчүүд хамгийн сайн сонсогчид болохыг Паул мэдсэн.
- Анхны сүмийн хэлбэр болох Иудейн синагогоос айлд үйлчлэлээ эхлэхийг Паул илүүд үзсэн.
- Маш үнэтэй нил өнгийн даавуу худалдагч Лидиа гэр чуулганы удирдагч болсон юм.
- Өмнөх ашиглаж байсан загварыг чуулганы хөгжлийн бодлогод тусгахгүй байж болно.

Г. Чуулган тарихад маш их золиос шаардагддаг.

- Паул, Силас нарын үйлчлэлийн хүчин чармайлт тэднийг шоронд оруулав. Тэд сайн дураараа золиос гарган үйлчилсэн. Бурханы төлөө зовж шаналсан ч Түүнд магтаалын дуунуудыг дуулж байв. (Үйлс 16:25)
- Эдүгээ чуулганы удирдагчид болон Есүсийн дагалдагчид ч бас сүм байгуулахад ижил төлөөсийг төлж байна. Шинээр сүм тарихын тулд маш олон цагийн залбирал, нулимс, хүнд хүчир хөдөлмөр, хүчин чармайлт, мөнгө, тэр бүү хэл цусаа хүртэл урсгах шаардлага гардаг.
- Паул Силас нарт учирсан зовлон бэрхшээлээс үл хамаарч Филлиппойн шоронгийн хуяг пастор болж, шинэ гэр чуулган бий болж байлаа.

Д. Бид Бурханы оршихуйд амьдарч, нөхцөл байдлаас үл хамааран Бурханы Ариун Сүнсэнд мэдрэмжтэй байх ёстой.

- Паул, Силас нар хэрцгийгээр зодуулж, харанхуй шөнөөр шоронд орсноо золиос хэмээн үзсэнгүй.
- Харин ч Бурханы Сүнс тэдэнд хүнд нөхцөл байдал дотор ялалтыг өгсөн гэдгийг мэдэж байлаа.

- Паул, Силас нар тэднийг Бурханы Сүнс удирдаж байгааг мэдэж байсан. Тэр тэдний төлөө санаа тавих болно гэдэгт итгэлтэй байсан. Филиппойн шоронд болсон газар хөдлөлт нь Бурхан ийм нөхцөл байдалд ч гэсэн оролцдог гэдгийг бидэнд сануулж байна. (Үйлс 16:25-26) Үйлчлэлийн маань үр дүн хүнд хэцүү болсон ч Тэр биднийг мартаж орхихгүй.
- Бид Их Эзэнийг дуулгавартай дагаж, Түүний хүслийг биелүүлэх аваас, Бурханы тогтоосон цагт Эзэн сүр жавхлант хүч чадлаа харуулах болно. Хэдийгээр ёрын муу нь Бурханы хаанчлалын хүчийг эсэргүүцэвч Бурханд төгсгөлийн үг нь байдаг.
- Бид Бурханы хаанчлалыг байгуулж, хүчирхэгжүүлээгүй. Бурхан Өөрийн хаант улсаа Өөрөө байгуулж байна.

Назарын Чуулганд чуулганыг тодорхойлохдоо: Өөрсдийн сүнсний өсөлтийн төлөө магтаал талархал өргөхөөр хамтдаа цугларч буй итгэгчдийн нэгдэл, эсвэл тогтсон цаг, товлосон газарт, томилогдсон удирдагчийн хамт цуглах зааврыг дагаж, Назарын Чуулганы номлол ба үйлчлэлд хөл нийлсэн бол сүм хэмээн хүлээн зөвшөөрч, бүсийн болон ерөнхий чуулганд (Ерөнхий Удирдлагын Зөвлөл) бүртгэж авч болно. Өөрөөр хэлбэл, Чуулган гэдэг нь итгэгчдийн нэгдэл болохоос байшин сав, эд хөрөнгө биш юм.

Е. Чуулганы хөгжлийн бодлого нь чуулганы түүхийн туршид өөрчлөгдөн хөгжсөн.

- Христийн цуглаан эхний 200 жилийн турш байшин барилгагүйгээр хийгдэж байжээ.
- Сүмийн байртай болох, эд хөрөнгөтэй болох, бүтэн цагийн пастортой байх зэрэг ойлголтууд сүүлд гарч ирсэн.
- Ариун Сүнс өнөөгийн чуулгануудыг шинэ арга замаар үр өгөөжтэй үйлчлүүлэхээр удирдаж байна.
- Чуулган бүр дүү сүмийг тарьдаг байх хэрэгтэй.
- Эдгээр дүү сүмүүд нь гэртээ эсвэл өөр боломжтой газарт цуглана.

- Пастор бүр үйлчлэлийн талбарт пастораар бэлтгэгдэж байгаа хамтран үйлчилдэг пастораа зөвлөн чиглүүлнэ.
- Энэхүү загварын дагуу шинэ сүм эхлэхэд санхүүжилт шаардлагагүй, шинэ цуглаан хийхэд эгэл хүмүүс ч Бурханы дуудлагад хариу өгч чадна.
- Мөн энэ загвар Бурхан Өөрийн чуулганаа дэлхий даяар шинэ газруудад тарих боломжийг олгодог. Зөвхөн Бурханы харааг шүүрэн авах зүрх сэтгэл, Түүний дуудлагад хариулах бэлэн байдал мөн Бурханы удирдамжийг хүлээн зөвшөөрдөг хүмүүс л Түүнд хэрэгтэй.

Ё. Чуулганы хөгжлийн зорилго нь шинэ хүмүүсийг Есүс Христ рүү авчрах юм.

- Есүс Эзэн тэдэнд *“Харин Тэр тэдэнд, “Би Бурханы хаанчлалыг өөр хотуудад бас тунхаглах ёстой. Энэ зорилгын тулд Би илгээгдсэн билээ гэв”*” гэж хэлэв. (Лук 4:43)
- Бид өөрсдийн амьдралаа чуулганы хөгжлийн төлөө өргөж байгаа Бурханы хаанчлалын элчин сайдууд билээ.
- Бидний зорилго бол тогтвортой байгууллагатай байх бишээ.
- Аль болох олон хүмүүс Есүс Христийн авралын мэдлэгт хүрээсэй гэж бид хүсдэг.
- Тэгээд бид тэдгээр шинэ итгэгчдийг Христийн дагалдагч болгохыг хүсдэг.
- Эзэн Есүс тэдэнд *“Та нар “Ургац хураалт болтол дөрвөн сар байна” гэж хэлдэг биш үү? Үзэгтүн, Би та нарт хэлье. Хараагаа дээшлүүлж, талбайг харагтун. Учир нь талбай цайрч хураалтанд бэлэн болжээ”*” гэв. (Иохан 4:35)

6. Өөрчлөлтийн Удирдагч

А. Христийг үлгэрлэн харуулдаг удирдагчдыг бид хүчирхэгжүүлэхийг зорьдог. Есүс бидний үлгэр жишээ билээ.

Өөрчлөлт хийдэг удирдагч бол Христтэй адил урирдагч мөн.

Б. Өөрчлөлтийн удирдагчид дуулгавартай бөгөөд даруу нэгнүүд байдаг.

- Эцэгийнхээ тааллын дагуу Өөрийгөө зориулсан Есүс Христийг тэд дагадаг. (Филиппой 2:5-8)
- Бурхан тэдний залбиралд хариулж, хэрэгцээг нь хангана гэдэгт тэд бат итгэдэг. (Иохан 15:7)
- Тэд эрх мэдэлд захирагддаг бөгөөд өөрсдийгөө өргөмжилдөггүй. (Ефес 5:21)

В. Өөрчлөлтийн удирдагчид үйлчлэгчид байдаг.

- Есүс Христ үйлчлүүлэхийн тулд биш харин бусдад үйлчлэхийн тулд ирсэн гэдэг үлгэр жишээг тэд дагадаг. (Марк 10:45, Матай 20:28)
- Зүрх сэтгэлийн ийм хандлагатайгаар тэд үйлчилдэг. (Филиппой 2)

Г. Өөрчлөлтийн удирдагч нар хараа зорилготой байдаг.

- *“Алсын хараа байхгүй бол ард түмэн дэг журамгүй байна”* (Сургаалт үгс 29:18)
- *“ЭЗЭН надад хариулан, “Үзэгдлийг уншсан нэгэн гүйн зугтахын тулд түүнийг тэмдэглэн, хавтангууд дээр сийлэн бич””* (Хабаккук 2:2)
- Эзэн Есүс Бурханы хаанчлалын тухай дүрслэлийг зурагласан, тиймээс бусдад тодорхой ойлгуулахын тулд бид ч бас Түүнтэй адил байх ёстой.
- Энэ шинж чанар нь дагалдагч ба удирдагчдын хоорондох ялгаатай талыг харуулж байна. Алсын хараатай удирдагч хүн сүм болон хүмүүсийн төлөө Бурханы харааг эрэн хайж, авсан тэр хараагаа цааш нь дамжуулж өгдөг.

Д. Өөрчлөлт хийдэг удирдагчид нарийн төлөвлөж боддог.

- Тэд хүмүүсийг Бурханы хаанчлалд ашиглагдах багаж болгон хувиргах чадвартай.
- Тэд Иссахарын хүүхдүүд шиг цаг үеийн нөхцөл байдлыг ойлгож, Библийн дагуух хариултыг олж чаддаг. (1Шастир 12:32)
- Бурханы хаанчлалд багтах хувьтай, авралд бэлтгэгдсэн сэтгэлүүдийг тэд таньж чаддаг.
- Ургацын талбайд ажиллах итгэгчдийг зоригжуулан илгээдэг болохоор тэд алсын хараагаа ажил хэрэг болгож чаддаг.

- Тэд эгэл даруу зорилготой, энгийн номхон үйлстэй хэдий ч хаанчлалын төлөвлөгөөнд оролцохдоо эрэмгий дайчны зүрхтэй нэгнүүд байдаг. (Лук 14:28-30)

Е. Өөрчлөлтийн удирдагч бол хамт олныг бүрдүүлэгчид.

- Есүс Их Эзэн бол бидний үлгэр дуурайл. Тэр ганцаараа бүх үйлчлэлээ хийхийн оронд харин баг бүрдүүлж, тэднийг хүчирхэгжүүлж байсан. (Матай 10)
- Эзэн Есүсийн шавь нар эгэл жирийн хүмүүс байсан хэдий ч тэд дэлхий ертөнцийг орвонгоор нь өөрчилсөн юм. (Үйлс 17:6)
- Чуулганы хүн бүр нь Бурханы хаанчлалын ажилд оролцдог багийг өөрчлөлтийн удирдагчид бүрдүүлдэг.

Ё. Өөрчлөлтийн удирдагчид энэрэнгүй сэтгэлтнүүд.

- Дагалдагч нараа сайнмэдээг дэлгэрүүлэх ажилд бэлтгэхдээ Эзэн Есүс тэдэнд “Тиймээс могой мэт ухаалаг, тагтаа мэт гэмгүй бай.” гэж заасан. (Матай 10:16)
- Нигүүлсэл ба хууль, шударга ёс ба өршөөлийг ариун байдал дотор хэрхэн тэнцвэртэй байлгахаа мэддэг байх ёстой.
- Тэд гаргасан шийдвэртээ эзэн байдаг ухаалаг шийдвэр гаргагчид байх ёстой.
- Тэдний гаргасан шийдвэрүүд нь энэрэнгүй сэтгэлтэй хосолсон байх ёстой.
- Тэд хайр дотор үнэнийг ярих ёстой. (Ефес 4:15)

Ж. Өөрчлөлтийн удирдагчид бусадтай ойлгомжтой харилцдаг.

- Есүс Христ дэлхий дээрх үйлчлэлийнхээ үеэр “Сонсох чихтэй нь сонсогтун” гэж олонтаа хэлсэн. (Матай 13:43) Есүс дагалдагч нараа тууштай бөгөөд хичээнгүйлэн сонсоосой хэмээн хүссэн.
- Өөрчлөлтийн удирдагчид Есүс Христ шиг тодорхой ойлгомжтой ярих ёстой.
- Өөрчлөлтийн удирдагчид ойлгомжтой, тодорхой, эрх мэдэлтэйгээр харилцахын чухлыг ойлгох хэрэгтэй. “Хэрэв бүрээ тодорхой дуугарахгүй бол хэн тулалдаанд бэлдэх вэ? (1Коринт 14:8)

З. Өөрчлөлт хийдэг удирдагч Бурханы хаанчлалыг үргэлжлүүлэн авч явах залгамж үеэ бэлтгэхэд нь бусдыг хүчирхэгжүүлдэг.

- Иошуа дараагийн удирдагчдыг босгож чадаагүй. Тэр зөвхөн өөрийнхөө үеийг л удирддаг байсан. (Шүүгчид 2:10)
- Өөрчлөлт хийдэг удирдагч бол түр зуурын эзэмшлийн төлөө удирдагч болоогүй, харин одоогийн болон дараагийн үеийнхнээ хоёуланг нь хамтад нь бэлтгэдэг.
- Тэд Бурханы хаанчлалын төлөө удирдагч болох хүмүүсийг сургаж, хурцалж, бэлтгэдэг нэгнүүдийг олж харж чаддаг, заан сургадаг бас зөвлөн тусалдаг.
- Залгамж үеэ бэлдэхгүйгээр ямар ч удирдагч амжилттай байж чадахгүй. *“Олон гэрч нарын өмнө надаас сонссон зүйлсийг бусдад заах чадвартай итгэмжит хүмүүст даатга”* (2Тимот 2:2)

7. Зорилго дагуулсан хайр энэрэл

А. Энэрэн хайрлах гэдэг нь Бурханы хайрыг харуулахыг хэлнэ.

- Бурхан Өөрийн Хүүгээ ертөнц рүү илгээж, Есүс Христ хүн төрөлхтний төлөө үхсэн нь Бурханы хайр болон энэрэнгүй сэтгэлийн хамгийн том бэлэг юм.
- Иохан 3:16-17-д Бурхан бидэнд хязгааргүй хайртай учраас Өөрийн Хүүг өгсөн бөгөөд бид мөнх амьтай болох боломжтой болсон гэжээ. Үүний адилаар 1Иохан 3:16-17-д хүн төрөлхтний төлөөх Бурханы хайр нь Бурханы бүтээлүүдийн төлөө цохилох сэтгэлтэй итгэгч бидний хайрын үйлсээр төгс илэрхийгддэг гэжээ.
- Тэр Нэгэн хүмүүсийн болон ертөнцийн төлөө хайраар хөтлөгдсөн гэдгийг Есүсийн амьдрал, үйлчлэл, үхэл ба амилалт харуулсан юм. (Матай 9:36)

Б. Хайрлан энэрэх үйлс үргэлж Эзэн Есүсийн нэрээр хийгддэг.

- Яаж энэрэн хайрлахыг Есүс Эзэн бидэнд харуулсан. Сайнмэдээний номонд Эзэн Есүс хүн төрөлхтний төлөө “зовох” сэтгэлийн гүн тээлттэйгээр үйлчилж байсан тухай гардаг.
- Ядуу, төөрөлдсөн, өвчтэй, гадуурхагдсан болон сул дорой хүмүүсийг Эзэн Есүс хайрлан халамжилдаг байсан.
- Бүрэн Бурхан, бүрэн Хүн болох Их Эзэн Есүс бидний хэрхэн амьдрах, яаж хайрлахын тод жишээ мөн.

Бид үйлчлэл, өгөөмөр сэтгэл эсвэл Эзэн Есүсийн нэрээр ирдэг өршөөл энэрлийг үйлдэл болгон бүхий л хичээл зүтгэлээр Есүс Христийн хайрыг өөрсдөөсөө харуулахыг хичээдэг.

В. Энэрэн хайрлах нь хүн бүрийн нэр хүндийг дээдлэхийг хэлнэ.

- Бурханы хүмүүс Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн Түүний бүтээлүүдийг хүндэтгэн дээдэлж, тэдэнд Есүсийн нэрээр итгэл найдвар өгч, хайрлан тусалдаг.
- Христ доторх Бурханы хайрыг түгээх шалтгаан хайрлан энэрэх сэтгэлээс өөр байхгүй.



Г. Жинхэнээсээ өөрчлөгдсөн итгэгчдээс л жинхэнэ хайр энэрэл аяндаа ундран гардаг.

- Чуулган бол Бурханы хайр ба энэрэнгүй сэтгэлийг энэ дэлхийд амилуулахаар дуудагдсан.
- Энэрлийн ажил нь хэзээ ч зөвхөн хүний хүчин чармайлт эсвэл нийгмийн идэвхээр хийгддэг ажил биш юм.
- Бид Христийн бие учраас бусдыг энэрэн хайрлах дуудлага маань Есүс Эзэний амьдрал ба Ариун Сүнсний заавраар хэлбэржиж, хүний амьдралын бүхий л хэсэгт цогцоор хүрч чаддаг билээ.
- Энэ дэлхийд бодит, нийгмийн болон сүнслэг өөрчлөлт хийхээр ажиллаж буй итгэгчдийн зүрх сэтгэлийг Ариун Сүнс өөрчилдөг.
- Чуулган бүрийн амьдрал ба үйлчлэлд байх салшгүй чухал бөгөөд байнгын идэвхтэй хэсэг бол хайр энэрэл зайлшгүй мөн.

Д. Хайрлан энэрэх нь цогц үйлчлэлийн талаарх Уэслийн тодорхойлолт юм.

- Бид Эзэнд үйлчлэн, ертөнцийг хайрлахаар Бурхан Эцэгээр илгээгдсэн, Ариун Сүнсээр хүчирхэгжүүлэгдсэн хүмүүс билээ.
- Бидний Аав хүн бүрийн амьдралд Сүнснийхээ хүчээр аль хэдийн ажиллаж байгаа бөгөөд энэхүү сайн үйлсэд нь бид ч бас дуудагдсан гэдэгтээ итгэдэг.
- Жинхэнэ сайнмэдээ нь эргэн тойрны хүмүүсийнхээ амьдралд нэвтрэн орж, тэдний амьдралын нэг хэсэг болох дуудлага ба зориулалтыг бидэнд өгдөг.
- Зовсон, сэтгэл нь шархалсан нэгэнтэй хамт байж, гачигдсан, гадуурхагдсан, доромжлогдсон нэгэнд итгэл найдвар, амар тайван, хайрыг Есүсийн нэрээр өгдөг хүмүүс бол бид.
- Бид хоорондоо хайрын нөхөрлөлөөр холбогддог ба нийгэмд сайнаар нөлөөлдөг. Бурхан ийнхүү Христийн Биеийг бүрэлдүүлж, тэлж байна.

Е. Цөхөрсөн дэлхийг аврах Бурханы ажилд оролцохоор өөрсдийгөө зориулсан бидний амьдралаас л *хайр энэрэл* урсан гарах учиртай.

- Туйлдсан, шархалсан хүн төрөлхтнийг Бурхан хэрхэн харж, сонсож, тэдэнд хариулж байсан шиг бид ч бас тийнхүү үйлдэх ёстой.
- Хүнийг зовлон зүдгүүрээс нь чөлөөлөх, энэ дэлхийд сэргэлт, элэг бүтэн амьдрал, аврал ба амар тайвныг тогтоохын төлөөх Бурханы

төлөвлөгөөг олж мэдэхийн тулд бид өөрт байгаа бүх нөөц бололцоогоо дайчилдаг.

- Цаашлаад бид ард түмнийг хавчин дарладаг шударга бус бүтцийг бий болгосон нийгмийн тогтолцоог засахын төлөө, дэлхий дээрх ёрын муугийн тогтолцоог нураахын төлөө Их Эзэн Есүсийн нэрээр хувь нэмрээ оруулах болно.
- Бид Эзэний ажлыг гүйцэлдүүлэн Бурханд алдрыг өргөхийн төлөө өөрсдийн хийж буй бүхнээрээ тус нэмэр болохыг зорьдог. (Мика 6:8)



УЭСЛИЙН ТЕОЛОГИ

ӨӨРЧЛӨХ ЧАДАЛТАЙ НИГҮҮЛСЛИЙН ГАЙХАМШИГ

“Нигүүлсэл бол бидний бүх гэм нүглээс агуу”. Ямар гайхамшигтай бодол вэ! Энэ бол магтан дууны эхний мөр юм.

Есүс Эзэний дотор, Бурхан хүн дүрээр ирж, ертөнцийг Өөртэйгээ эвлэрүүлэхээр шийдсэн юм. (Иохан 3:15-16, Ром 1:1-16) Биднийг гэмтнүүд байхад, Бурхан Өөрийн Хүүгээ бидний гэм нүглийн төлөө “эвлэрлийн тахил” болгон өргөв. (Ром 3:25) Бүх бүтээлийн Эзэн дэлхийн нүгэл хилэнцийг Өөртөө үүрч, бидэнд авралыг өгсөн юм!

Есүс Христийн дотор, Бурханы зөвт байдал, Түүний аврал илчлэгдсэн. (Ром 3:21) Хэрэв ингээгүй бол бүх хүн төрөлхтөн ямар ч найдлагагүйгээр Бурханаас таслагдах байлаа. (Ефес 1:5-2:10) Тиймээс биднийг Бурханаас салгах гэсэн бүх хүчнүүд ялагдсан юм. (Колоссай 2:15) “Есүс Христэд итгэх итгэлээр” дамжуулан (Ром 3:22) бид одоо эрх чөлөөтэй болсон ! (Ром 8:2)

Бурханд магтан дууллыг тасралтгүй өргөх хэмжээлшгүй бялхлыг Шинэ Гэрээ бидэнд соёрхсон. (Ефес 1:6-10) Христ дотор Бурханы бялхам дүүрэн нь бодитоор оршдог бөгөөд Христийг хүлээн авсан хүмүүс Түүний бялхам дүүрэнд орох болно. (Колоссай 2:8-15) Паул Бурханы нигүүлслийг амссаныхаа дараа *“Аяа, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн баялаг нь ямар гүн гүнзгий вэ!”* хэмээн дуу алдсан байдаг. (Ром 11:33)

Эдгээр баялгуудын зарим нь нүглийн уучлал, бидний дотор оршин буй Сүнс, Христийн дүр төрх, мөнхийн амьдрал, Бурханы амар тайван, ариусгал, чуулганы нөхөрлөл, Их Эзэнийг эргэж ирэхэд найдах найдвар билээ.

Эзэн Есүсийн ярьж байсан, хүмүүсийн сонссон “сайнмэдээ” нь угтаа Бурхан нүгэлтнүүдийг ямар ч төлөөсгүйгээр Өөртэйгөө эвлэрүүлэхийг л хэлж байсан юм. Хүмүүсийн үзэн яддаг татвар хураагч, үйлдэл дээрээ баригдсан завхай эмэгтэй ч Бурханы хайрыг сонсон гэмшиж, уучлагдсанаар мөнх амьдралыг хүлээн авах боломжтой болсон. Түүний тааллыг олохын тулд юу ч хийж чадахгүй гэдгээ хүлээн зөвшөөрдөг хүмүүст Бурхан Өөрийгөө үнэгүйгээр өгдөг. (Лук 15)

Биднийг ухаарч мэдэхээс ч өмнө Ариун Сүнс биднийг авралд хүргэхийн төлөө ажиллаж байдаг. Бурханы дуу хоолой хүрээгүй газар гэж үгүй хэмээн Дуулал номонд хэлжээ. (Дуулал 19:3) Мөн Паул цаг хугацаа өнгөрөх тусам бүх бүтээлүүд оршин тогтнохын тулд Христээс хамааралтай байх болно гэсэн. (Колоссай 1:15-17) Христ хүн бүрийг гэгээрүүлдэг хэмээн Иохан тунхагласан. (Иохан 1:9)

Ариун Сүнс хувь хүний амьдрал, нийгмийн түүхэнд сайнмэдээний зам гаргахаар Бурханы бүтээлч ба итгэлтэй байдалд нийцсэн хэлбэрээр ажиллаж байна. Тэрээр бодитоор тунхаглагдахаас нь урьтан хүмүүсийн зүрхийг Сайнмэдээг хүлээж авахад нь бэлддэг.

Эргэн харахад, Христитгэлтнүүд цөм Ариун Сүнсний гаргасан замаар явж авралд хүрсэн байдаг. Энэхүү “угтан тоссон нигүүлсэл”, эсвэл өмнөөс угтах нигүүлсэл ч гэж хэлж болох Бурханы бэлдсэн нигүүлслээс бидний аврал хамаарсан билээ.

Бурхан ямагт бидний төлөө байдаг. Хүүгээрээ дамжуулан гүйцэлдүүлсэн бүхнээ Тэр одоо бидэнд Ариун Сүнсээр дамжуулан мэдүүлдэг билээ. Яг үнэндээ, Эцэг Хүүгийнхээ дотор гүйцэт болгосон тэр л авралаас бүх бүтээл хүртсэн юм. (Ром 8:19-25)

Бурхан нүглүүдийг нь уучилж, гэмтнүүдтэй эвлэрэх нигүүлсэнгүй үйлсийн нэрийг бид зөвтгөл гэдэг. Зөвхөн итгэлээр дамжуулан Бурханы таалал уруу эргэснээр зөвтгөгддөг.

Зөвтгөл бол Бурханы авралын ажлын нэг л жишээ юм. Удаах ач холбогдол нь гэмшсэн нүгэлтний дотор амийг өгөхөөр Бурханы Сүнс оршин байдаг. Тэр хүн Бурханы Сүнсээр шинэчлэгдэн, дахин төрдөг юм. Сүнслэг амьдралын энэ шинэ ойлголтыг Шинэ Гэрээнд шинэ бүтээл, шинэ төрөлт, дээрээс төрөх, мөнхийн амь, Бурханы хаанчлалд орох, шинээр амьдрах, Сүнсээр амьдрах зэргээр нэрлэдэг.

Таны ямар хэлээр ярьдгаас үл хамааран, тэнгэрлэг ивээлийн гайхамшгаар Ариун Сүнс Христитгэлтнүүд дээр оршин байдаг бөгөөд тэднийг өөрчлөн шинэчилсээр байдаг. Үхсэн ч амьдрах болно, дайн дажин болсон ч Бурханы амар тайван хамт байна, цөхөрсөн ч итгэл найдвар байсаар байх болно. Шинэ гэрээнд *“Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна! Энэ бүхэн Бурханаас ирдэг бөгөөд Тэрээр биднийг Христээр дамжуулан Өөртэйгөө эвлэрүүлэв”* (2Коринт 5:17-18а) гэсэн.

Шинэ Гэрээнд Христитгэлтнүүдийг “Христ дотор”, Христ тэдний дотор байдаг гэсэн. Нэг үгээр хэлбэл, Христитгэлтнүүд одоо Бурхантай эвлэрсэн учир итгэлээрээ тэд “Христ дотор” байж (Ром 8:1), Түүний дотор байгч нэгэн нь гэмшсэн нүгэлтнүүдийг Эцэгтэй эвлэрүүлдэг гэж ойлгож болно.

Шинэ Гэрээнд бидний доторх Христийг “алдрын найдвар” гэдэг. (Колоссай 1:27) Ариун Сүнсээр дамжуулан үхлээс амилсан Христ Өөрийн амиа Өөрийн

хүмүүсийн дотор бүрэлдүүлсэн. Тэр тэдний дотор амьдарч, тэднээс Сүнсний үр жимсийг гаргадаг. (Галат 5:22-23)

Гэхдээ, “Яг жинхэнээсээ Христэд итгэвэл миний сүнслэг амьдрал ямар байх бол? Хуучин гэмт зуршлууд амьдралаас минь салахгүй бол яах вэ? Эсвэл, Бурханы Сүнс надад сайн сайхан амьдралыг өгөх болов уу?” гэх мэт маш олон асуулт гарч болно. Шинэ Гэрээ энэ асуултад, *“Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс аугаа”* (1Иохан 4:4) хэмээн хариулсан.

Есүс Христийг үхлээс амилуулсан тэр л хүч Түүнийг үхэл, там, нүгэл болон булшийг ялсан Ялагч болгосон бөгөөд одоо Ариун Сүнсээрээ бидний дотор ажилласаар байна. (Ефес 1:9) Урьд нь нүглийн хуучин хууль үйлчилж байсан бол харин одоо *“Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ”* (Ром 8:2)

Бүх Христитгэлтнүүдийн хувьд баяр хөөрийн хэм хэмжээ нь тэд Ариун Сүнсээр дүүрч, махан биеийн дагуу бус харин Сүнсний дагуу амьдрахаас шалтгаалдаг. (Ром 8:1-8) Та амьдралдаа Бурханы өөрчлөх чадалтай нигүүлслийн гайхамшгийг амсаж байсан уу?

“Өөрчлөх чадалтай Нигүүлслийн Гайхамшиг” эссе бичлэгийг *Бурханыг Таньж Мэдэх нь Библи Судлал® 2000 (The Reflecting God Study Bible® 2000)* номноос авсан болно. Зондерван Корпорацийн Библийн зохиогчийн эрх. Хэвлэгчийн зөвшөөрлөөр ашиглана. Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.



НАЗАРЫН ЧУУЛГАН*

ИТГЭЛИЙН ТУНХАГ

ОРШИЛ

Бурхан биднийг ариун болгохоор өгсөн өв болох итгэл, ялангуяа номлол сургаал болон хоёр дахь нигүүлсэлд тооцогддог төгс ариусгалыг чандлан мөрдөхийн тулд, мөн Бурханы хаанчлалыг тэлэхийн төлөө Есүс Христийн бусад Чуулгануудтай идэвхтэйгээр хамтран ажиллаж, үйлчлэгчид, Назарын сүмийн ажилтнуудын хувьд өөрсдийн мөрддөг дүрэм журам, баримталдаг зарчмыг сахиж, суурь бичиг баримт болох Назарын Чуулганы Үндсэн Дүрэм, Итгэлийн Тунхаг, Христэч Зан Төлөвийн Гэрээ болон Байгууллагын ба Удирдлагын бодлогыг хүлээн зөвшөөрч дараах зүйлсийг мөрдлөг болгоно. Үүнд:



I. Гурвал Бурхан

1. Нэг мөнх оршихуй, хязгааргүй оршигч Бурхан, бүрэн эрхэт Бүтээгч ба ертөнцийг Тогтоон баригч бол цор ганц Бурхан мөн ба Түүний мөн чанар, зорилго нь ариун гэдэгт бид итгэдэг. Ариун бөгөөд хайр, гэрэл болох Бурхан Гурвалаар оршдог бөгөөд Эцэг, Хүү, Ариун Сүнсээр Өөрийгөө илчилсэн.

(Эхлэл 1, Левит 19:2, Дэд Хууль 6:4-5, Исаиа 5:16, 6:1-7, 40:18-31, Матай 3:16-17, 29:19-20, Иохан 14:6-27, 1Коринт 8:6, 2Коринт 13:14, Галат 4:4-6, Ефес 2:13-18, 1Иохан 1:5, 4:8)



II. Есүс Христ

2. Бид Гурвал шинжит Бурханы хоёр дахь бодгаль болох Есүс Христэд итгэдэг. Тэрээр мөнхөд Эцэгийн хамт байсан гэдэгт итгэдэг. Мөн Ариун Сүнсээр бүтээгдэж, онгон Мариас мэндэлсэн ба нэгдмэл төгс чанараар оршин байдаг Бурхан бол Хүн буюу жинхэнэ Бурхан, жинхэнэ Хүн, Бурхан-Хүн гэдэгт итгэдэг. Есүс Христ бидний гэм нүглийн төлөө үхсэн бөгөөд Тэр

үнэхээр үхлээс амилан, хүн төрөлхтний төгс чанартай холбоотой бүх зүйлийн хамт Өөрийн биеийг дахин авч, тэнгэрт өргөгдөн, бидний төлөө зуучлан залбирдаг гэдэгт бид итгэдэг.

(Матай 1:20-25, 16:15-16, Лук 1:26-35, Иохан 1:1-18, Үйлс 2:22-36, Ром 8:3, 32-34, Галат 4:4-5, Филипой 1:12-22, 1Тимот 6:14-16, Еврей 1:1-5, 7:22-28, 9:24-28, 1Иохан 1:1-3, 4:2-3, 15).



III. Ариун Сүнс

3. Ариун Сүнс нь Гурвал Бурханы гурав дахь бодгаль гэдэгт бид итгэдэг. Тэр эхнээсээ оршин байсан бөгөөд Христийн цуглаанд байнга идэвхтэйгээр ажилладаг, дэлхийд гэм нүглийг нь илчилж, гэмшин итгэсэн хүмүүсийг сэргээн шинэчилж, итгэгчдийг ариусган, Есүсийн үнэн дотор бүхий л үнэнээр хөтлөн дагуулдаг.

(Иохан 7:39, 14:15-18, 26, 16:7-15, Үйлс 2:33, 15:8-9, Ром 8:1-27, Галат 3:1-14, 4:6, 3:14-21, 1Тесалоник 4:7-8, 2Тесалоник 2:13, 1Петр 1:2, 1Иохан 3:24, 4:13).

IV. Ариун Бичээс



4. Бидний авралын төлөө тэнгэрлэг удирдамжаар өгөгдсөн Хуучин ба Шинэ Гэрээний 66 ном нь байж болох боломжит бүх зүйлсийг багтаан бичигдсэнд итгэдэг. Бурханы хүслийг ямар ч алдаа мадаггүйгээр илэрхийлсэн Ариун Бичээсийн сүнслэг эрх мэдэлд бид итгэдэг. Бичээст багтаагүй юу ч бидний итгэлийн тунхагт орох нь зохисгүй.

(Лук 24:44-47, Иохан 10:35, 1Коринт 15:3-4, 2Тимот 3:15-17, 1Петр 1:10-12, 2Петр 1:20-21)



V. Төрөлхийн ба хүний гэм нүгэл

5. Бидний өвөг дээдсийн дуулгаваргүй байдлаас болж гэм нүгэл дэлхийд орж ирснээр хүн үхдэг болсон гэдэгт бид итгэдэг. Хоёр төрлийн гэм байдаг нь төрөлх гэм нүгэл буюу гажуудал завхрал, санаатай буюу хүний зориуд үйлддэг гэм нүгэл гэдэгт бид итгэдэг.

5.1. Төрөлхийн гэм буюу гажуудал завхрал гэдэг нь Адамаас болж хүмүүний мөн чанар гажсан учраас хүн төрөлх зөвт байдлаас, бүтээлийн эхнээс

байсан эцэг өвгөдийн цэвэр ариун байдлаас таслагдан, Бурханы зэвүүцлийг үүрч, сүнслэг амьдралаас хаягдаж, ёрын мууд олзлогдон амьдрах болсныг хэлж байна гэдэгт бид итгэдэг. Цаашдаа ч төрөлх гэм нүгэл нь Ариун Сүнсний баптисмаар дамжуулан хүний зүрх сэтгэл бүрэн цэвэрших хүртэл шинэ амьдрал дотор маань байсаар байх болно гэдэгт бид итгэдэг.

5.2. Төрөлх гэм нүгэл нь санаатай гэм нүглээс ялгаатай бөгөөд төрөхөөс өвлөгддөг гэмт чанар нь санаатай гэм болон хувирах шинжтэй учраас зөвхөн тэнгэрлэг эрх мэдлээр эсэргүүцэн таслахаас нааш хэн ч зогсоож чадахгүй гэдэгт бид итгэдэг.

5.3. Санаатай буюу хүний зориуд үйлддэг гэм бол ёс суртахууны хувьд хариуцлага хүлээх чадвартай хүн Бурханы хуулийг мэддэг мөртлөө өөрийн дур хүслээс болон үйлдэж буй зөрчил гэдэгт бид итгэдэг. Тиймээс үүнийг санаатайгаар гэм хийх, зугтан зайлах боломж өгөлгүй харван орж ирдэг өвчин тусах, буруу зүйл хийх, алдаа гаргах, бүтэлгүйтэх болон Уналтын үр дүнгээс улбаалсан төрөлх гажуудлуудтай андуурч болохгүй. Хэдийгээр, иймэрхүү ноцтой аюулгүй мэт шинжүүд нь Христийн сүнсний эсрэг илт тэрслэх, Түүнд сөрөг хариу үйлдэл үзүүлж буй хэлбэр биш боловч эцсийн дүндээ үүнийг сүнсний гэм нүгэлд тооцож таарна. Хүний хийж буй гэм бол хайрын хуулийн эсрэг хийж буй тэрслэл яах аргагүй мөн бөгөөд Христтэй харилцах харилцаагаар тайлбарлавал үүнийг үл итгэл гэж үзнэ.

(Төрөлх гэм нүгэл: Эхлэл 3, 6:5, Иов 15:14, Дуулал 51:5, Иеремиа 17:9-10, Марк 7:21-23, Ром 1:18-25, 5:12-14, 7:1-8:9, 1Коринт 3:1-4, Галат 5:16-25, 1Иохан 1:7-8,

Санаатай гэм нүгэл: Матай 22:36-40, {хамт 1Иохан 3:4}, Иохан 8:34-36, 16:8-9, Ром 3:23, 6:15-23, 8:18-24, 14:23, 1Иохан 1:9-2:4, 3:7-10)

VI. Эвлэрэл



6. Есүс Христ туулсан зовлон, урсгасан цус, загалмай дээрх үхлээрээ дамжуулан бүх хүн төрөлхтний нүглийн төлөө бүрэн дүүрэн, төгс эвлэрүүллийг хийсэн бөгөөд энэхүү эвлэрэл нь авралын суурь болоод зогсохгүй Адамын үр удмын хүн бүрт хүртээмжтэйгээр өгөгдсөн гэдэгт бид итгэдэг. Эвлэрэл бол ёс суртахууны хувьд хариуцлага хүлээх чадваргүй хүмүүс бас гэм зэмгүй хүүхдүүдэд маш их ач тустай төдийгүй зөвхөн гэмээ улайж, итгэх түвшинд хүрсэн хэнийг ч авралд авчрах чухал үр өгөөжтэй.

(Исаиа 53:5-6, 11, Марк 10:45, Лук 24:46-48, Иохан 1:29, 3:14-17, Үйлс 4:10-12, Ром 3:21-26, 4:17-25, 5:6-21, 1Коринт 6:20, 2Коринт 5:14-21, Галат 1:3-4, 3:13-14, Колоссай 1:19-23, 1Тимот 2:3-6, Тит 2:11-14, Еврей

2:9, 9:11-14, 13:12, 1Петр 1:18-21, 2:19-25, 1Иохан 2:1-2)



VII. Угтал Нигүүлсэл

7. Хүн төрөлхтөн Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдэхдээ зөв, буруугийн хоорондохыг сонгох чадвартай, ухамсрын хувьд хариуцлага үүрэх чадамжтай байсан боловч Адамын гэм буруугаас болж гажуудан завхарсан учраас буцаад өөрсдийн төрөлх мөн чанараараа гэмээс эргэж, өөрсдийн үйлсээ итгэлээр үйлдэж, Бурханыг дуудах чадваргүй болсонд бид итгэдэг. Бид бас Бурханы нигүүлсэл нь Есүс Христээр дамжуулан бүх хүмүүст үнэгүйгээр өвлөгдөж, гэм нүглээс зөвт байдал руу эргэхийг хүссэн хэнд ч боломж олгон, өршөөгдөн ариусгагдахын төлөө Есүс Христэд итгэн, Түүний таалалд нийцсэн сайн үйлсийг мөшгөдөг гэдэгт итгэдэг.

Сэргээгдэн шинэчлэгдэж буй болон бүрэн гүйцэт ариуслыг туулж яваа бүх хүмүүс хэдийгээр гэм нүглээ улайсан ч нигүүлслээс салан ухарвал ямар ч найдлагагүйгээр мөнхөд алдагдах болно гэдэгт бид итгэдэг.

(Бурханлаг байдал ба ёс суртахууны үүрэг хариуцлага: Эхлэл 1:26-27, 2:16-17, Дэд хууль 28:1-2, 30:19, Иошуа 24:15, Дуулал 8:3-5, Исаиа 1:8-10, 31:29-30, Езекиел 18:1-4, Мика 6:8, Ром 1:19-20, 2:1-16, 14:7-12, Галат 6:7-8; Төрөлх чадваргүй байдал: Иов 14:4, 15:14, Дуулал 14:1-4, 51:5, Иохан 3: 6, Ром 3:10-12, 5:12-14, 20а, 7:14-25; Үнэгүй өгөгдсөн нигүүлсэл ба итгэлийн үйлс: Езекиел 18:25-26, Иохан 1:12-13, 3:66, Үйлс 5:31, Ром 5:6-8, 18, 6:15-16, 23, 10:6-8, 11:22, 1Коринт 2:9-14, 10:1-12, 2Коринт 5:18-19, Галат 5:6, Ефес 2:8-10, Филиппой 2:12-13, Колоссай 1:21-23, 2Тимот 4:10а, Тит 2:11-14, Еврей 2:1-3, 3:12-15, 6:4-6, 10:26-31, Иаков 2:18-22, 2Петр 1:10-11, 2:20-22)



VIII. Гэмшил

8. Өөрсдийн санаатай ба санамсаргүй үйлдлээрээ Бурханы эсрэг нүгэл үйлддэг бүх хүнээс гэмээ ухармсарлан, хүлээн зөвшөөрч, буруугаа ойлгосны улмаас өөрийн хүслээр гэм нүглээсээ эргэхийг шаарддаг үйлдлийг гэмшил гэдэгт бид итгэдэг. Гэмшсэн хүн бүрт Бурханы Сүнс амийн өршөөл ба сүнслэг амьдралд итгэж чадах зүрх сэтгэлийн цагаатгал, өршөөлийн найдварыг өгдөг.

(Шастирын дэд 7:14, Дуулал 32:5-6, 51:1-17, Исаиа 55:6-7, Иеремиа 3:12-14, Езекиел 18:30-32, 33:14-16, Марк 1:14-15, Лук 3:1-14, 13:1-5,

18:9-14, Үйлс 2:38, 3:19, 5:31, 17:30-31, 26:16-18, Ром 2:4, 2Коринт 7:8-11, 1Тесалоник 1:9, 2Петр 3:9)



IX. Зөвтгөл, Шинэчлэл болон Үрчлэл

9. Зөвтгөл бол Есүс Христийг Эзэн ба Аврагч хэмээн хүлээж зөвшөөрч, Түүнд итгэсэн хүнийг зөвтөд тооцдог Бурхан тэдний бүх гэм бурууг өршөөн уучилж, гэмийн төлөөс болох шийтгэлээс бүрэн чөлөөлөхийн тулд үзүүлж буй Түүний аугаа нигүүлсэнгүй шүүлтийн хариу үйлдэл гэдэгт бид итгэдэг.

9.1. Дахин төрөлт буюу шинээр төрөлт нь Бурханы нигүүлсэнгүй ажил бөгөөд гэмшсэн итгэгчийн ёс суртахуунт мөн чанар нь сүнслэг хурдаар өсөж, түүнд цоо шинэ сүнслэг амьдрал өгөгдсөнөөр итгэл, хайр ба дуулгавартай байдалд чадварждаг гэдэгт бид итгэдэг.

9.2. Үрчлэл бол зөвтгөгдсөн, шинэчлэгдсэн итгэгч хүн бүрийг хүүгээ болгодог Бурханы нигүүлслийн үйлдэл гэдэгт бид итгэдэг.

9.3. Зөвтгөл, Дахин төрөлт, Үрчлэл нь Бурханыг эрэлхийлэгчдийн амьдралд нэгэн зэрэг хийгддэг ажил бөгөөд гэмшлээр дамжуулан итгэлээр хийгддэг, гэхдээ энэхүү нигүүлслийн ажлын гэрчлэгч нь Ариун Сүнс гэдэгт бид итгэдэг.

(Лук 18:14, Иохан 1:12-13, 3:3-8, 5:24, Үйлс 13:39, Ром 1:17, 3:21-26, 28, 4:5-9, 17-25, 5:1, 16-19, 6:4, 7:6, 8:1, 15-17, 1Коринт 1:30, 6:11, 2Коринт 5:17-21, Галат 2:16-21, 3:1-14, 26, 4:4-7, Ефес 1:6-7, 2:1, 4-5, Филиппой 3:3-9, Колоссай 2:13, Тит 3:4-7, 1:23, 1Иохан 1:9, 3:1-2, 9, 4:7, 5:1, 9-13, 18)



X. Христэч Ариун байдал ба Бүрэн Ариусгал

10. Ариусгал гэдэг нь итгэгчдийг Христтэй адил болгон өөрчлөх Бурханы ажил гэдэгт бид итгэдэг. Энэ нь Ариун Сүнсээр дамжуулан анхны ариусгал эсвэл дахин төрөлт (зөвтгөлийн хамт нэгэн зэрэг), бүрэн ариусгал, Бурханыг алдаршуулах Ариун Сүнсний цаашдын ажлыг төгс төгөлдөр болгох Бурханы нигүүлслийн ажлаар хэлбэрждэг. Түүний алдар дотор буй бид Хүүгийн дүр төрхөөр улам бүр батаждаг билээ.

Бүрэн ариусгал нь биднийг тасралтгүй шинэчилдэг Бурханы ажил бөгөөд үүний улмаас итгэгчид төрөлх гэм нүгэл, гажуудал завхралаасаа чөлөөлөгдөн өөрсдийгөө Бурханд, мөн хайрыг улам төгөлдөржүүлдэг ариун дуулгаварт чанарт бүрэн зориулдаг гэдэгт бид итгэдэг.

Энэ нь Ариун Сүнсний дүүргэлт, баптисмаар хэлбэржиж, зүрх сэтгэлийг гэм нүглээс цэвэрлэн, Ариун Сүнсний оршихуй нутагшин оршиж, итгэгчдийг

амьдрал, үйлчлэлд бэлтгэдэг.

Бүрэн ариусгал нь Есүс Христийн цусаар өгөгдсөн ба төгс адислагдсан бидний итгэлээр дамжуулан нигүүлслээр хэлбэрждэг бөгөөд энэхүү нигүүлслийн ажлыг Ариун Сүнс гэрчилдэг.

Энэ ойлголт нь “Христэч төгс байдал”, “төгс хайр”, “цэвэр зүрх сэтгэл”, “Ариун Сүнсний дүүргэлтээр баптисм хүртэх”, “бялхам дүүрэн ерөөл”, “Христэч ариун байдал” зэрэг олон янзаар нэрлэгддэг.

10.1. Цэвэр зүрх сэтгэл болон төлөвшсөн зан чанарын хооронд тодорхой ялгаа бий гэдэгт бид итгэдэг. Эхнийх нь бүрэн ариусгалын улмаас шууд ирдэг, дараагийнх нь нигүүлсэл доторх өсөлтийн үр дүнгээс хамаардаг.

Бүрэн ариусгалын нигүүлсэл нь биднийг Христтэй адил дагалдагч болон өсөхөд тэнгэрлэг түлхэц өгдөг гэдэгт итгэдэг. Тиймээс энэ түлхэц заавал байх ёстой тул итгэгч хүний зайлшгүй шаардлага болсон Христийн үлгэр дуурайллаар амьдрахыг хүссэн хувь хүний сүнслэг ахиц дэвшил, өсөлт хөгжилтийн үйл явцад няхуур хандах хэрэгтэй. Ийм хичээл зүтгэлгүйгээр та харалган болж, тэр чигтээ нигүүлслээс таслагдан, мөнхөд алдагдах боломжтой.

Нигүүлсэлд оролцох буюу ялангуяа нөхөрлөл, сахилга бат, чуулганы үйл ажиллагаанд оролцоно гэдэг нь итгэгчид нигүүлсэлд өсөж, Бурханыг болон хөршөө бүх зүрх сэтгэлээрээ хайрлах хайраар дүүрнэ гэсэн үг.

(Иеремиа 31:31-34, Езекиел 36:25-27, Малахи 3:2-3, Матай 3:11-12, Лук 3:16-17, Иохан 7:37-39, 14:15-23, 17:6-20, Үйлс 1:5, 2:1-4, 15: 8-9, Ром 6:11-13, 19, 8:1-4, 8-14, 12:1-2, 2Коринт 6:14-7:1, Галат 2:20, 5:16-25, Ефес 3:14-21, 5:17-18, 25-27, Филиппой 3:10-15, Колоссай 3:1-17, 1Тесалоник 5:23-24, Еврей 4:9-11, 10:10-17, 12:1-2, 13:12, 1Иохан 1:7, 9) (“Христэч төгс байдал”, “төгс хайр” 30:6, Матай 5:43-48, 22:37-40, Ром 12:9-21, 13:8-10, 1Коринт 13, Филиппой 3:10-15, Еврей 6:1, 1Иохан 4:17-18, “Цэвэр зүрх сэтгэл”: Матай 5:8, Үйлс 15:8-9, 1Петр 1:22, 1Иохан 3:3 “Ариун Сүнсээр баптисм хүртээх”: Иеремиа 31:31-34, Езекиел 36:25-27, Малахи 3:2-3, Матай 3:11-12, Лук 3:16-17, Үйлс 1:5, 2:1-4, 15: 8-9 “Бүрэн дүүрнээр ерөөгдөх”: Ром 15:29 “Христэч ариун байдал”: Матай 5:1-7: 29, Иохан 15:1-11, Ром 12:1-15:3, 2Коринт 7:1, Ефес 4:17-5:20, Филиппой 1:9-11, 3:12-15, Колоссай 2:20-3:17, 1Тесалоник 3:13, 4:7-8, 5:23, 2Тимот 2:19-22, Еврей 10:19-25, 12:14, 13:20-21, 1Петр 1:15-16, 2Петр 1:1-11, 3:18, Иуда 20-21)



XI. Чуулган

11. Есүс Христийг Эзэн хэмээн хүлээн зөвшөөрсөн, Бурханаар тамгалагдсан, Христ дотор шинэчлэгдсэн, Ариун Сүнсээр дэлхийн өнцөг булан бүрээс хамтдаа Христийн Биеэр дуудагдсан, санаа нийлсэн хүмүүсийн цуглаан бол Чуулган мөн гэдэгт бид итгэдэг.

Бурхан Чуулганыг Сүнсний эв нэгдэл, нөхөрлөлийг амьдралаараа үлгэрлэн харуулдаг, Үгийн тунхаглалаар дамжуулан магтаал өргөдөг, сүмийн ёслолыг сахидаг, Түүний нэр дээр үйлчилдэг, Христэд дуулгавартай байдаг, ариун амьдралтай, хамтын хариуцлагатай байхаар дуудсан.

Дэлхий дээрх чуулганы үйлчлэлийн зорилго нь Сүнсний хүчээр Христийн гэмшлийн ба эвлэрүүллийн үйлчлэлийг хуваалцахад оршино. Сүм өөрийн үйлчлэлийг сайнмэдээ тараах, боловсролоор дамжуулан дагалдагч бэлтгэх, хүмүүсийг өрөвдөн энэрэх, шударга ёсны төлөө ажиллах, Бурханы хаанчлалыг гэрчлэх үйлсээр гүйцэлдүүлж байна.

Чуулган нь үндэснийхээ соёл, ёс заншилд тулгуурлан өөрийн хэлбэр бүтцийг тодорхойлдог бөгөөд үндэсний болон олон улсын чуулганы аль алиных нь биеийн нэг хэсэг байж, онцгой үйлчлүүдэд хүмүүсийг тусгайлан дуудахаар зохион байгуулагдсан түүхэн бодит үйлчлэл мөн. Бурхан Чуулганыг Түүний удирдлагад захирагдаж, Их Эзэн Есүс Христийг дахин ирэхэд сонор соргог, бэлэн байхаар дуудсан.

(Египетээс гарсан нь 19:3, Иеремиа 31:33, Матай 8:11, 10:7, 16:13-19, 24, 18:15-20, 28:19-20, Иохан 17:14-26, 20:21-23, Үйлс 1:7-8, 2:32-47, 6:1-2, 13:1, 14:23, Ром 2:28-29, 4:16, 10:9-15, 11:13-32, 12:1-8, 15:1-3, 1Коринт 3:5-9, 7:17, 11:1, 17-33, 12:3, 12-31, 14:26-40, 2Коринт 5:11-6:1, Галат 5:6, 13-14, 6:1-5,15, Ефес 4:1-17, 5:25-27, Филиппой 2:1-16, 1Тесалоник 4:1-12, 1Тимот 4:13, Еврей 10:19-25, 1Петр 1:1-2, 13, 2:4-12, 21, 4:1-2, 10-11, 1Иохан 4:17, Иуда 24, Илчлэлт 5:9-10)

XII. Баптисм



12. Эзэний тушаасан Христэч баптисм нь Есүс Христийн төлсөн төлөөсийн ач тусыг хүлээн зөвшөөрч байгаагийн илэрхийлэл болгон хийгддэг ёслол гэдэгт бид итгэдэг бөгөөд Есүс Христ бол Аврагч мөн гэдэгт бат итгэсэн

хүмүүст зориулагдсан, ариун байдал доторх дуулгавартай болон зөвт байдлыг зорилгоо болгодог үйлчлэл юм.

Баптисм бол Шинэ Гэрээний билэгдэл. Эцэг эх эсвэл асран хамгаалагчдын зүгээс Христэч сургалт авч, баталгаажуулсны үндсэн дээр тэдний хүсэлтээр бага насны хүүхдүүд баптисм хүртэж болно.

Баптисмыг усаар шүршиж норгох, дээрээс нь ус асгах, мөн усанд бүхэлд нь булхуулах зэргээр тухайн хүний сонголтоор хийж болдог.

(Матай 3:1-7, 28:16-20, Үйлс 2:37-41, 8:35-39, 10:44-48, 16:29-34, 19:1-6, Ром 6:3-4, Галат 3:26-28, Колоссай 2:12, 1Петр 3:18-22)



XIII. Эзэний Зоог

13. Бидний Их Эзэн Аврагч Есүс Христийн анхлан барьж байсан Эзэнийг дурсах Ариун зоог бол Шинэ Гэрээний нэн чухал ёслол бөгөөд үүгээр дамжуулан итгэгчид амь ба аврал, Христ доторх бүх сүнслэг ерөөлүүдийг хүлээн авдаг, Түүний үхлийн золиосыг тунхагладаг гэдэгт бид итгэдэг. Энэ нь гарцаагүй Түүний хийсэн бүхэнд талархдаг хүмүүст зориулагдсан ба үүгээрээ тэд Их Эзэний үхлийг Түүнийг дахин ирэх хүртэл дурсан санаж буйгаа харуулж байгаа юм. Ариун Зоогийг Христэд итгэсэн, ариун хүмүүсийг хайрладаг хүмүүс барих учиртай.

(Египетээс гарсан нь 12:1-14, Матай 26:26-29, Марк 14:22-25, Лук 22:17-20, Иохан 6:28-58, 1Коринт 10:14-21, 11:23-32)



XIV. Тэнгэрлэг эдгэрэл

14. Гайхамшигт эдгэрлийн тухайд бид Библийн сургаалд итгэдэг бөгөөд өвчтэй нэгний эдгэрлийн төлөө итгэлээр залбирахыг уриалдаг. Бурхан анагаах ухаанаар дамжуулан эдгээдэг гэдэгт бид итгэдэг.

(Хаадын Дэд 5:1-19, Дуулал 103:1-5, Матай 4:23-24, 9:18-35, Иохан 4:46-54, Үйлс 5:12-16, 9:32-42, 14:8-15, 1Коринт 12:4-11, 2Коринт 12:7-10, Иаков 5:13-16)



XV. Христийн хоёр дахь ирэлт

15. Их Эзэн Есүс Христ дахин ирнэ гэдэгт бид итгэдэг. Түүнийг дахин ирэхэд

амьд байгаа хүмүүс Христ Есүс дотор нойрсогсдоос түрүүлж явахгүй, гэвч хэрэв бид Түүн дотор байх аваас Их Эзэнтэй уулзахаар ариун хүмүүсийн хамт тэнгэрт аваачигдан Эзэнтэй үүрд хамт байх болно гэдэгт итгэдэг.

(Матай 25:31-46, Иохан 14:1-3, Үйлс 1:9-11, Филиппой 3:20-21, 1Тесалоник 4:13-18, Тит 2:11-14, Еврей 9:26-28, 2Петр 3:3-15, Илчлэлт 1:7-8, 22:7-20)

XVI. Амилалт, Шүүлт, болон Хувь тавилан



16. Зөвт ба зөвт бус хүмүүсийн бие үхлээс дахин амилж, сүнстэйгээ нэгдэн “сайныг үйлдсэн нь амийн амилалт руу, харин ёрын мууг үйлдсэн нь хараалын амилалт руу” орно гэдэгт бид итгэдэг.

16.1. Хүн бүр Бурханы өмнө зогсож амьдралдаа хийсэн үйлийнхээ төлөө шүүгдэх хожмын тэр шүүлтэнд бид итгэдэг.

16.2. Есүс Христ бидний Их Эзэн гэдэгт итгэж аврагдсан, Түүнийг дуулгавартайгаар дагасан бүгдэд сүр жавхлант мөнхийн амьдрал өгөгддөг харин гэмшээгүй хүн тамд үүрд мөнхөд тарчлах болно гэдэгт бид итгэдэг.

*** 1976 оны Ерөнхий Чуулганы хөтөлбөрөөр Бичээсийн тайлбаруудыг Итгэлийн Тунхагт оруулсан ба энэ нь Үндсэн Дүрмийн зүйл заалт биш болно.**



ЧУУЛГАНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

ХРИСТИЙН АРИУН ЧУУЛГАН

“Бурханы хүмүүс” хэмээн Бичээст хэлсний дагуу бид өөрсдийгөө “нэгэн цул, ариун, нэгдмэл, элчийн чуулганы” нэг хэсэг гэж итгэлтэйгээр тодорхойлно. Христийн чуулган уруу хийсэн баптисм нь Бурханы урьдчилсан буюу авралын нигүүлслийг гэрчилсэн хувь хүний болон хэсэг хүмүүсийн гэрчлэл юм. Бид үйлчлэлээ “Бурханы чуулган дотор” хийдэг бөгөөд чуулганууд маань дэлхий дахины чуулгануудын бүрэн илэрхийлэл болдог. Дэлхий дахинаа Христийн амьд биеийг төлөөлөн тэнгэрлэг ивээлийн багаж байхаар Ариун Сүнсээр сонгогдсон Бурханы сүм ба Бурханы ариун байдлын сүнслэг учир шалтгаан мөн гэдэгтээ итгэдэг. Бурханыг магтан хүндлэх нь хүний амьдралын чин зорилго мөн гэдэг үнэнийг Христийн сүм гэрчилдэг.

Тиймээс чуулган гэмтнийг гэмшилд, амьдралыг нь илүү дээр амьдралд дуудаж, ариунаар амьдрагсдыг бялхам дүүрэн итгэлийн хамтын амьдралаар дамжуулан халамжилж, итгэгчдийг ариусгагдсан амьдралд урин дууддаг билээ. Чуулганы ариун бөгөөд итгэмжтэй байдлаар Бурханы хаанчлал дэлхийд харагддаг учраас чуулган нь өөрөө өөрийнхөө хэлж буй үгээрээ хэмжигддэг билээ.

БУРХАНЫ ЭРХЭМ ЗОРИЛГОТОЙ НИЙЦЭХИЙН УЧИР

Бурханы зорилго нь дэлхий дээрх хамгийн эрхэм, эн тэргүүний зорилго бөгөөд оргүй хоосноос орчлон ертөнцийг байгальтай нь, түүхтэй нь, бурханлаг төрхт хүнтэй нь, тэнгэрлэг хайрын ундаргатай нь хэлбэржүүлэн бүтээсэн Түүнээс бидний үйлчлэл ба зорилго улбаатай.

Гэм бүтээлийг сэвтүүлэхтэй зэрэгцэн “бүх бүтээлийг Бурханы бүтээлийн зорилгын дагуу дахин сэргээх” гэсэн авралын мөн чанар илчлэгдэн гарч ирсэн. Хүмүүнийг дахин шинэчлэх нь суурь ойлголт байсан.

Жон Уэсли ариусгалыг “Бурханы дүр төрхийн дагуу бидний зүрх сэтгэлийг шинэчлэх”, өөрөөр, “зөвт байдал болон жинхэнэ ариун байдал” гэж тодорхойлжээ. “Бүх үндэстний ерөөл бол” хэмээн “үр удмыг нь ерөөхийн тулд Абрахамыг дуудсан дуудлагад Бурханы эрхэм зорилго харагддаг” (Эхлэл 12:1-2) бөгөөд энэ нь Цорын Ганц Бурханд гэрчлэлийг өргөн, Нэрийг нь үндэстнүүдийн дунд тунхаглан алдаршуулдаг Еврейчүүдийн түүхэнд тод томруунаар үлдсэн байдаг.

Бидний Эзэн Есүс Христээр дамжуулан Өөрийгөө бүрэн гүйцэт илэрхийлсэн Бурхан бол Ариун Гурвалаар оршин байдаг гэдгийг Христэд итгэгчид мэддэг билээ. Ариун Сүнс биднийг Бурханы зорилго дотор оролцоотой байлгахаар урин дуудаж, хүчирхэгжүүлж байдаг. Чуулган нь тэрхүү гэрээнд нэгдэж, амьдралын нэгэн хэсэг болохынхоо хувьд үндэстнүүдийг үргэлжлүүлэн ерөөж, эдгээсээр байна. Хэдийгээр бид Бурханы эрхэм зорилгын дотор бусад Христэд итгэгчидтэй хамтран ажилладаг ч аливаа улс үндэстний хил хязгаараас шалтгаалахгүйгээр Христ сүмийг бүх үндэстэнд өгсөнчлөн бид олон үндэстний чуулган гэсэн өөрсдийн урсгал чиглэлийн алсын хараагаа ямагт тээж явдаг.

ДЭЛХИЙД ХРИСТ ШИГ ҮЙЛЧЛЭХИЙН УЧИР

Христэд үйлчлэлийн үндэс нь Христийн дотор Бурханы хайрыг гэрчлэн харуулах Библийн эрх мэдэл юм. Итгэгчид өөрсдийгөө Христийн дагалдагч боллоо гэдгээ усан баталгаа хийлгэн олон нийтэд гэрчлэн харуулж баталдаг. Итгэмжит дагалдагч байх нь бидний доторх Бурханы дотогш чиглэсэн нигүүлслийг гадагш чиглэлтэйгээр илтгэн харуулах илэрхийлэл ба “Бурхан үнэхээр хайрласан учраас” дэлхий дээрх ажлуудаар нь дамжуулан илэрхийлэгдэж буй Түүний тэнгэрлэг ивээл гэж үзэж болно. Христийн

биеийн бүх гишүүд бүгд үйлчлэлд бэлтгэгдсэн бөгөөд ялангуяа сүмийн удирлагад дуудагдсан хүмүүс элчийн үйлчлэлд томилогдсон хүмүүс байдаг. Тэдний дуудлага нь хувийн гүн гүнзгий итгэл үнэмшил дээр суурилдаг.

Үндэсний болон бүсийн чуулганы ажилтан, удирдлагууд өгөгдсөн бэлэг авьяастай хүмүүс байх бөгөөд бүсийн чуулганд үйлчлэлийн дуудлагатай хүмүүсийг сонгон томилдог. Үг болон Ширээний үйлчлэл гол хариуцлага нь биш учраас үйлчлэгчид мэргэжлийн үйлчлэлд томилогддог. Харин ахлагчид Сайнмэдээ тараах, ариун зан үйлүүдийг хийж гүйцэтгэх, магтаал хүндэтгэлд хүмүүсийг халамжлах, чуулганы үйл ажиллагааг сахиулах зэрэг үүрэг хариуцлага хүлээнэ.

Бүсийн болон төв оффисын удирдлагуудыг удирдах ажилтны чуулганы хуралдаанаас сонгон томилно. Бүсийн удирдлага нь тухайн бүсийнхээ чуулганууд, гишүүд ба ажилтнуудыг хоньчлох, сүнслэг шууд удирдлагаар ханган ажиллах үүрэгтэй. Ерөнхий удирдлагууд нь нийт Назарын урсгалын өмнө элчийн ба пасторын үйлчлэлийг гүйцэтгэх бөгөөд сургаал номлол, ариун байдал, Христийн амьдралыг өөрсдийн амьдрал, үйлчлэлээр үлгэрлэн харуулах, бүх сүм цуглаануудаар дамжуулан алсын хараагаа хэрэгжүүлэхэд анхаарч үйлчилдэг. Тэдний үзэл бодол нь олон улсын түвшинд байх ёстой. Энэхүү үзэл бодол нь чуулганы биеийн өөр өөр хэсгүүдийн алсын хараа болон хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, дэлхий даяар хэрэгцээтэй газруудад нөөц боломжуудыг хуваарилан хүртээхэд гар бие оролцож, чуулганы санаа зорилгыг нэгтгэхэд оршино. Хэд хэдэн бүсийн чуулга уулзалтаар болон бусад хэлбэрийн үйлчлэлүүдээр дамжуулан удирдлагын зүгээс үндэс угсаа, эдийн засаг, арьс өнгө, хэл соёлын хувьд ялгаатай Назарын урсгалын чуулгануудын эв нэгдлийг хангаж ажиллахыг гол чиглэлээ болгохыг уриалсан.



УДИРДЛАГЫН БҮТЭЦ

Назарчууд өөрсдийгөө нэгэн санаа зорилготой бүх дэлхийн чуулган гэж үздэг. Цаашлаад, Бичээсийн дагуу чуулганы засаглал нь тогтсон хэлбэр, бүтэцгүй гэж үздэг учраас бид өөрсдийн удирдлагын бүтцийг Библийн эсрэг бол юуг ч хүлээн зөвшөөрөхгүй гэсэн зарчимд тулгуурлан санаа нэгтэйг тодорхойлдог. Ийм тодорхой ойлголттой байснаар Зорилго нь бүтцээ тодорхойлоход дөхөмтэй болдог. (2013-2017 Бодлого, Түүхийн Тайлбар, 17-19-р хуудас)

Назарын чуулганы хувьд Методист Эпископ бүтцийн ардчилсан хувилбар болох сүм ба нийгмийн удирдлагууд дуу хоолойгоо өргөж болдог хэлбэрийг баримталдаг бөгөөд энэ нь эпископын албанд тодорхой хязгаар тогтоосон. Назарын чуулганы бүтцийн зарим энгийн шинжийг дор харуулъя.

- Удирдлагын гурван түвшинд бид ажилладаг, үүнд:
 1. Сүм чуулган бүр жил бүрийн бүсийн чуулга уулзалтад оролцох төлөөлөгчдийг сонгоно.
 2. Бүсийн чуулга уулзалтаас дөрвөн жил тутамд хуралддаг ерөнхий чуулга уулзалтад оролцох төлөөлөгчийг сонгоно.
 3. Ерөнхий чуулга уулзалтаас гаргасан шийдвэрүүдийг бүх чуулган, тэдгээрийн салбар нэгжүүд хэрэгжүүлэх ёстой.

- Ерөнхий чуулга уулзалтаас Назарын урсгалын ерөнхий үйлчлэлийг удирдах зөвлөлийг сонгож, бүх чуулганыг удирдах эрхийг өгдөг. Тэд нэг ерөнхий чуулга уулзалтаас дараагийн чуулга уулзалтыг хүртэл сонгогдоно. Ерөнхий зөвлөлийн удирдагч нэг бүр өөрт харъяалагдах бүсийг хариуцах бөгөөд жил бүр бүсийн чуулга уулзалтыг зохион байгуулж, хариуцсан бүсийнхээ хүрээнд шинэ үйлчлэгчдийг томилох үүрэгтэй. Ерөнхий удирдлагын тоо өнгөрсөн цаг хугацаанд өөрчлөгдөж байсан боловч 1960 оноос хойш зургаан хүнтэй байхаар тогтсон байна. Энэ зургаан хүн хамтдаа Ерөнхий Удирдлагын Зөвлөлийг бүрдүүлж, жил болгон хэд хэдэн удаа хуралддаг.
- Ерөнхий чуулга уулзалтаас Ерөнхий Удирдлагын Зөвлөлийг сүмийн болон нийгмийн салбарт ажилладаг удирдлагын тоо тэнцүү байхаар тогтож сонгоно. Энэ зөвлөл жилд нэг удаа хуралдаж, сүмийн ерөнхий удирдлагууд, хэлтсийн даргуудыг томилно. Тэд сүмийн ерөнхий үйлчлэлийн бодлого, төсөв, үйл ажиллагааг хянах үүрэгтэй.
- Байршлаасаа хамаарч сүм чуулганууд аль нэг бүсэд харъяалагдах бөгөөд тэднийг бүсийн удирдлага удирдана. Үйлчлэлийн зорилгоосоо хамаарч бүсийн хурал зохион байгуулагдах ба жилд нэг удаа бүсийн чуулга уулзалт хийнэ. Бүсийн чуулга уулзалтаас бүсийн удирдах зөвлөлийг сонгодог бөгөөд зөвлөл нь сүм чуулган болон пасторуудыг халамжлах, шинээр сүм тарих, бүсийн эрүүл байдлыг ханган ажиллахад анхаарах ёстой.
- Сүмүүд дотроо зөвлөлдөн пасторуудыг нэр дэвшүүлж, бүсийн удирдах зөвлөлөөс зөвшөөрөл өгсний үндсэн дээр томилох бөгөөд өөрсдийн санхүү болон үйл ажиллагаагаа хариуцан ажиллана.
- Назарын бүсүүдийг газарзүйн бүс болгон хуваадаг. (жнь: Африкийн бүс, Ази-Номхон далайн орнуудын бүс гэх мэтчилэн) Газарзүйн бүсүүд нь удирдах засаглалын гэхээсээ илүү хараа зорилгынхоо хувьд ач холбогдолтой.
- Итгэлцлийн нөхцөлтэйгээр сүмийн барилга болон бүсийн өмч хөрөнгийг бий болгодог.
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэн нь ч ялгаагүй сүмийн үйлчлэл ба албанд удирдах ажил гүйцэтгэж болно.
- Бид Назарын Чуулганы Бодлогыг өөрсдийн баримтлах ном гэж үздэг. Ерөнхий чуулга уулзалтаар Бодлогод өөрчлөлт оруулж болно.

(Эхлэл 18:25, 1Самуел 2:10, Дуулал 50: 6, Исаиа 26:19, Даниел 12:2-3, Матай 25:31-46, Марк 9:43-48, Лук 16:19-31, 20:27-38, Иохан 3:16-18, 5:25-29, 11:21-27, Үйлс 17:30-31, Ром 2:1-16, 14:7-12, 1Коринт 15:12-58, 2Коринт 5:10, 2Тесалоник 1:5-10, Илчлэлт 20:11-15, 22:1-15)



ЧУУЛГАН

ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН

Назарын Чуулган гэмийг уучилж, Есүс Христийн дотор Ариун Сүнсний хүчээр зүрхийг шинэчилдэг, өөрчлөх хүч чадалтай Бурханы нигүүлсэл рүү бүх хүнийг ирээсэй гэж хүсдэг.

Бидний эн тэргүүний зорилго бол “үндэстнүүдэд Христийн дагалдагчдыг бэлтгэх”, итгэгчдийг нөхөрлөл, гишүүнчлэл (сүмийн), итгэлээр хариулж буй хүн бүрийг бэлтгэн (зааж сургах) зохион байгуулахад оршино. Итгэлийн ахан дүүсийн эцсийн зорилго нь эцсийн өдөрт хүн бүрийг Христийн дотор төгөлдөржүүлэхэд оршдог. (Колоссай 1:28)

Энэ нь аварч, төгөлдөржүүлж, зааж бас итгэгчдэд байр суурь өгдөг үндэсний чуулган билээ. Үндэсний чуулган бол Христийн Бие бөгөөд бидний итгэл ба үйлчлэлийн илэрхийлэл мөн.

БҮСИЙН ЧУУЛГАН

Үндэсний чуулганууд нь эрх мэдлийн хувьд тодорхой нэг хэсэг буюу бүсэд харьяалагдана.

Бүсэд харилцан хамаарал бүхий үндэсний чуулганууд багтах бөгөөд үйлчлэлээрээ бие биенийгээ дэмжин, нөөц бололцоогоо хуваалцаж, хамтын ажиллагаагаа холбон ажиллана.

Тухайн бүсэд харьяалагддаг чуулгануудыг бүсийн удирдлагууд, харин бүсийн зөвлөлтэй хамтран чиглүүлэн ажиллах үүргийг бүсийн удирдлагын зөвлөл хүлээнэ.

ЕРӨНХИЙ ЧУУЛГАН

Назарын Чуулганы Бодлогод тусгагдсан итгэл үнэмшил, бүтэц, тодорхойлолт, үйл ажиллагаан дээр Назарын чуулганы эв нэгдлийн үндэс тогтдог.

Энэхүү эв нэгдлийн мөн чанар нь Чуулганы Бодлого дахь Итгэлийн Тунхагт орсон байгаа. Бид бүсийн бүх чуулгануудад эдгээр баримт бичгүүдийг өөрсдийн хэлээр орчуулан, өргөнөөр тараан хүртээж, хүмүүст зааж өгөхийг уриалдаг. Назарчууд бид өөрсдийгөө урнаар шаглан, нэгэн сайн ёрог даавуу хийх нь бидний хувьд алтан сүлжмэл бүтээх мэт үйл хэрэг билээ.

Энэхүү эв нэгдлийн бодит төлөөллийг “Назарын Чуулганы номлолын төлөвлөлт, бодлого боловсруулалтын эрх барих дээд удирдлага” болох Ерөнхий Чуулган илтгэн харуулна. (Чуулганы Бодлого 300)

Хоёр дахь төлөөлөл бол бүх чуулганыг төлөөлдөг олон улсын Ерөнхий Төлөөлөн Удирдах Зөвлөл юм.

Гурав дахь төлөөлөл нь Чуулганы Бодлогыг тодорхойлдог Ерөнхий Удирдлагын Зөвлөл ба тэд соёлын онцлогийг харгалзан аливаа үйлчлэлүүдийг заавар зөвлөгөөгөөр хангаж ажилладаг.

Назарын чуулган хэлбэрийн хувьд төлөөлөх байр суурьтай ба нэг талдаа хэт епископ буюу номчирхсон арга барилаас, нөгөө талдаа хязгаарлалтгүй хамтын чуулганчлах үзлээс зайлсхийдэг.

Чуулган бол бүхнээс илүүгээр нэгдмэл байх ёстой. Харилцан уялдаатай гэсэн үг. Биднийг зангидсан холбоосууд хэзээ ч тасарч мэдэх ширхэг утаснаас илүү бат бэх байх ёстой. Бидний нийтлэг холбоосын эх үндэс нь юу вэ? Гарцаагүй Есүс Христ мөн. (Назарын Чуулганы Бодлого 2013-2017)



НЭГДМЭЛ ЧУУЛГАН

Назарын Чуулган бол хоорондоо нягт холбогдсон "ариун нэгдэл" юм. Энэ нь чуулганы бие даасан шинжийг алдагдуулдаггүй мөн итгэл үнэмшлийн хувьд ямар ч амьд харилцаагүй мөртлөө зорилго чиглэлийнхээ хувьд зарим талаараа ижил төстэй чуулгануудын хоорондох хамтын ажиллагаа, урсгал чиглэл огт биш.

Ямар ч шалтаг тоочихгүйгээр чуулган хоорондоо холбогдох ёстой.

Үүгээр бид “үндэстэнд Христийн дагалдагчийг бэлтгэх” давхар зорилго тээсэн, бүсчилсэн зохион байгуулалттайгаар харилцан бие биенээсээ хамаарал бүхий үндэсний чуулганы нэгэн биеийг илтгэн харуулж байгаа юм. Бидэнд байгаа нийтлэг итгэлийн дагуу нэр төрөө өндөрт өргөн, хийж буй үйлчлэлийнхээ хүрээнд бие биендээ хариуцлагатай хандах зориулалтыг бид гаргах ёстой.

Бид нэгдмэл чуулганыхаа хувьд:

- Итгэлээ хуваалцдаг
- Үнэ цэнээ хуваалцдаг
- Эрхэм зорилгоо хуваалцдаг
- Үүрэг хариуцлагаа хуваалцдаг

Үүрэг хариуцлагаа хуваалцах гэдэгт Дэлхийн Эвангелийн Сан болон онцгой зорилго бүхий үйлчлэлээр дамжуулан санхүүжилт босгох үүрэг хариуцлага багтана.

1908 оноос хойш Назарчууд дэлхийн үйлчлэлээр дамжуулан Христийн дагалдагчдыг бүх үндэстэнд бэлтгэсээр байна.

Христийн төлөө хүрч очсон газрууд өргөжин тэлсээр байна. Та залбирч, өгөөмрөөр өгснөөрөө ганцаараа хийж чадахаасаа ч илүү ихийг бусадтайгаа хамтран хийж чадна. Танай чуулганы өргөсөн өргөл бүхэн үйлчлэлийг санхүүжүүлэх зорилготой байдаг.

Бүгд адилхан өргөх биш харин бүгд адил тэгш золиос гаргах зарчмыг Назарын Чуулган баримталдаг. Энэ бол дэлхийн эдийн засаг, хөгжиж буй улс орнуудыг хамарсан дэлхийн чуулгануудын хувьд маш чухалд тооцогдох Библийн байр суурь билээ.

Дэлхийн Эвангелийн Сан олон чиглэлээр санхүүжилтийн төлөвлөгөөтэй ажилладаг. "Зорилго руу санхүүжилт хийх" гэсэн нэр томъёог та бүхэн сонсож байсан байх. Энэ бол Дэлхийн Эвангелийн Сангаас дэлхийн зарим улс орнуудад хэрэгжүүлж байсан үйлчлэлийн ажлын олон төрлийн арга замыг тодорхойлж, санхүүжүүлж байснаас ч илүү өргөн ойлголт юм.

Дэлхийн үйлчлэлийн бүс нутгуудад хэрэгжих Чуулганы алсын хараа, үйл ажиллагааг дэмжих нь бидний амин чухал зорилго билээ. Иймээс үйлчлэлийг санхүүжүүлэх нь чуулганы хувьд олон олон хүний төлөө өргөж буй агуу золиос юм.

Дэлхий даяар өргөсөн нийт мөнгөн дүнг харвал дунджаар 86.1 хувь нь үндэсний буюу нутгийн чуулгануудад зарцуулагджээ. Санхүүжилтийн 4.5 орчим хувийг бүсийн үйлчлэлд ашигласан байна. Назарын коллежуудад суралцдаг оюутнуудад боловсрол олгох, тэднийг итгэлээр дагалдуулахад 1.8 орчим хувийг зарцуулсан. Энэ нь танай чуулганы мөнгөний 7.6 хувь нь илгээлтийн эзэд, дэлхийн үйлчлэлүүд мөн бусад онцгой хэрэгцээт үйлчлэлүүдэд зориулагдахаар Дэлхийн Эвангелийн Санд очжээ гэсэн үг.

Эндээс таны өргөл ч бас бусдыг сургах, дагалдуулах, хүүхэд, залуучууд, насанд хүрэгсдэд Сайнмэдээг хүргэх үйлсэд зориулагдсаныг харж болох нь ээ. Та өргөх тусмаа Назарчуудтай нэгдмэл чуулган мэт холбогдон, эмтэрсэн нэгнийг хайрлан, дэлхий дээрх алдагдсан сэтгэлийг бэдрэн олж, үндэстэнд Христийн дагалдагчдыг бий болгож чадна.

НАЗАРЧУУД ҮЙЛЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ САНХҮҮЖИЛТИЙГ ХЭРХЭН БОСГОДОГ ВЭ:



Дэлхийн Эвангелийн Сан болон Онцгой үйлчлэл гэдгийг илгээлтийн эздийг илгээж, үндэсний удирдлагыг сурган, сайнмэдээний сургагч багш нар, дагалдагчдыг томилон, Назарын хойч үеийг бэлтгэснээр чуулганы хувьд биелэлээ олдог нэг төрлийн хариуцлагаа хуваалцаж буй хэлбэр гэж ойлгож болно.

ХРИСТИТГЭЛТ. АРИУН. ҮЙЛЧЛЭГЧ

Анхны Назарын Чуулганы ерөнхий удирдлагын зөвлөлийн дарга байсан Файнис Ф.Бресигийн зорилго бүрэн хэрэгжсэнийг бид гэрчилнэ. Тэр эхнээсээ л дэлхийн бөмбөрцгийг “Эзэний аврал ба ариун байдал”-аар бүрхэх Назарын Чуулганы “тэнгэрлэг зураглалын” талаар ярьж байсан юм.

Назар хүн бүр хаана ч байсан энэ алсын хараанд бодит далайцтайгаар оролцдог.

Өөрчлөгдсөн амьдрал болгоноос бүрэн төгс авралын тухай Уэслийн Ариун байдлын сургаалын гэрчлэлийг харж болно.

“Үндэстэнд Христийн дагалдагчдыг бэлтгэх” чуулганы эрхэм зорилго нь бидэнд сүнслэг хүч өгөгдсөний зэрэгцээ Их Эзэний өгсөн бүхий л нөөц бололцоонуудад сайн нярвын сэтгэлээр хандахыг бидэнд сануулдаг.

Алсын хараа Бурханаас ирдэг, тиймээс бидний хараа зорилго бол дотор маань нутагладаг Ариун Сүнсний удирдамжаар өгөгддөг хамгийн дээд тушаал юм.

Бид “тансаг өвийг” дээдлэн эрхэмлэдэг ч чуулганы хувьд үүнээс буцах, эсвэл байсан чигээр нь үлдээж болохгүй.

Есүс Христийн дагалдагчийнхаа хувьд бид хотыг байгуулахаар урагшилсаар байх ёстой. “Тэр хотын уран барилгачин ба барилгачин нь Бурхан мөн” (Еврей 11:10)

Харагтун, Бурхан бүх зүйлийг шинэ болгоно!

1. Назарын чуулганы хорьдугаар Ерөнхий Чуулга Уулзалтын сэтгүүл (1980):232. Франклин Күүк, Олон Улсын Цар Хүрээ (1984):49.

2. Эдгээр үгс батламж болон гэрчилгээн дээр бичигддэг.

3. Рожер Л. Ханн “Есүсийн доторх Бурханы Алсын Хараа”, “Бурханы Хаанчлалыг Заах”, Кейт Шванз болон Иосеф Колесон, Миссио Дей: Уэслийн талаарх Ойлголт (2011) 58.

4. Жон Уэсли, Номлол, II Боть (1902) х. 373; Жон Уэсли, Христэч Төгс Байдлын Тодорхой Тайлбар, Ж.Э.Вүүд, Жон Уэслийн заасан Христэч Төгс Байдал. (1885) 211

БИД

1

Эцэг,
Хүү,
Ариун
Сүнс
бол Нэг
Бурхан
гэдэгт
итгэдэг

2

Ариун
Сүнсээр
бичигдсэн
Хуучин,
Шинэ
Гэрээнд
бидний
Христэч
амьдрал
болон
итгэлд
шаардлага-
тай бүх
үнэн
агуулагд-
даг гэдэгт
итгэдэг

3

Хүн
анхнаа-
саа гэмт
чанартай
төрдөг
учраас
бузар
муу руу
гажиж,
одоо ч
гэм
хийдэгт
итгэдэг

4

Гэмшээ-
гүй хүн
эцэстээ
ямар ч
найдлага-
гүй болж,
үүрд
алдаг-
дана
гэдэгт
итгэдэг

5

Есүс
Христээр
дамжуулан
ирсэн
эвлэрүүлэл
нь нийт хүн
төрөлхтний
төлөө учраас
гэмшин, Эзэн
Есүс Христэд
итгэсэн хэн ч
зөвтгөдөн,
шинэчлэгдэн
, гэмийн
боолчлолоос
чөлөөлөгдөх
болно гэдэгт
итгэдэг

6

Их Эзэн
Есүс
Христэд
итгэх
итгэлээр
дамжуу-
лан
Түүнд
итгэгчид
бүрэн
ариусгаг-
дан,
тасралт-
гүй
шинэчлэ
гддэгт
итгэдэг

7

Биднийг
шинээр
төрснийг,
мөн бүрэн
ариус-
саныг
Ариун
Сүнс
гэрчилдэг
гэдэгт
итгэдэг

8

Бидний Их
Эзэн эргэж
ирнэ,
үхэгсэд
амилах
болно,
эцсийн
шүүлт
болно
гэдэгт
итгэдэг

